



НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

ЖИЛИЙН ТАЙЛАН 2009

ГАРЧИГ

ӨМНӨТГӨЛ 3

ЗАСАГЛАЛЫН ХӨТӨЛБӨР

| | |
|---|----|
| ХҮНИЙ ЭРХ | 7 |
| ШҮҮХИЙН ХАРААТ БУС БАЙДАЛ | 10 |
| ТӨРИЙН ИЛ ТОД, ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДАЛ, ИРГЭНИЙ НИЙГМИЙН ОРОЛЦОО | 11 |
| ХЭВЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ | 17 |
| ЧӨЛӨӨТ, ШУДАРГА СОНГУУЛЬ | 19 |

ЭДИЙН ЗАСГИЙН ХӨТӨЛБӨР

| | |
|--|----|
| ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГА | 25 |
| ОЛБОРЛОХ САЛБАРЫН БОДЛОГЫН АСУУДЛУУД | 27 |
| ТӨСВИЙН ИЛ ТОД БАЙДАЛ БА ИРГЭДИЙН ОРОЛЦОО | 28 |
| ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ | 29 |
| БИЗНЕСИЙН ОРЧИН | 30 |
| ОРОН НУТГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ | 31 |

НИЙГМИЙН ХӨТӨЛБӨР

| | |
|--|----|
| ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САНААЧИЛГА..... | 35 |
| ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН ЭРХИЙН ХАМГААЛАЛ | 38 |
| НИЙГМИЙН ЭМЗЭГ БҮЛЭГТ ЗОРИУЛСАН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ | 39 |

| | |
|--|----|
| ХӨГЖЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТӨВ | 41 |
| ПОРТАЛ САЙТ | 42 |
| БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР | 44 |
| ЭРДМИЙН ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР | 45 |
| ХЭВЛЭН НИЙТЛЭЛ | 46 |
| ОРЧУУЛГЫН ТӨСӨЛ | 47 |

БУСАД ХАВСРАЛТ

| | |
|---------------------------|----|
| Дорно Дорно хөтөлбөр..... | 49 |
| Санхүүгийн тайлан | 51 |
| Ажилтнууд | 58 |

ӨМНӨТГӨЛ БҮЮУ 2009 ОНЫГ ЭРГЭН ДҮГНЭХЭД

Парламентын засаглалтай Монгол Улсын хувьд шинэ засгийн газар бүрэлдэж, үйл ажиллагааны хөтөлбөрөө УИХ-аар батлуулж, ажлын эрч хүч нь ид жигдэрч цэгцэрдэг агуулгаараа УИХ-ын сонгуулийн дараагийн жил чухал онцлогтой байдаг. 2009 он бол чухам ийм ерөнхий дүр төрхтэй жил байсан агаад энэ онд Монгол Улсын төрийн тэргүүн, Ерөнхийлөгчийг шинээр сонголоо.

2008 оны УИХ-ын сонгуулийн дүн гарсны дараахан болсон үйл явдлаас үүдэн Монгол Улсад бий болсон өвөрмөц нөхцөл байдал улс төрийн өрнөлийн голлох хүчин зүйл болж хувирсан юм. Хэдийгээр уг сонгуульд МАХН ялалт байгуулсан дүн гарсан ч Ардчилсан намтай хамтран Засгийн газраа байгуулах шийдэл энэ үед тохиосон үйл явдлуудын оргил нь байсан бөгөөд өнөөдрийг хүртэлх бүх үйл явц “хамтран ажиллах дүрмийн” дагуу улс төрийн өрсөлдөөний сонгодог зүй тогтоос гадуур явагдаж байна. Ийнхүү хамтран ажилласан нэгэн жил болох 2009 онд улс төржилтийн бай болж олон он дамжуулан шийдлээ хүлээж ирсэн улс орны хөгжлийн зарим чухал асуудлыг шийдэхэд нааштай нөлөөлсөн ч сөрөг хүчингүй, хяналтгүй, цөөн улстөрчдийн тохиролцсоноор улс үндэсний хөгжлийн нийтлэг эрх ашгаас гүйвсан хуудуутай шийдэл

гарах эрсдлийг мөн дагуулсан юм. Үүний тод жишээ нь 2009 онд парламентаас ямааны ноолуурын нөхөн төлбөр, УИХ-ын гишүүдийн 76 тэрбум, улмаар УИХ-ын сонгуулийн үеэр амалсан бэлэн мөнгийг олгох зэрэгт улс орны эдийн засгийн хүчин чадлыг тэр чиггээр нь татан оруулсан явдал боллоо.

Энэхүү нөхцөл байдалд засаглалын хяналт-тэнцвэрийг хангагч институциудийн хараат бус үйл ажиллагаа, тэдгээрийн дорвitoй шинэтгэлийг нэхсэн уур амьсгал бүрэлдэж эхлэв. Сүүлийн 20 жил үргэлжилж буй шүүх эрх мэдлийн шинэтгэлийг үр нөлөөтэй болгож, бие даасан, шударга шүүхийн тогтолцоог төлөвшүүлэх шаардлага энд юун түрүүнд хамаарах ч бодлого боловсруулагчдын олонхи нь үүнийг хүлээн зөвшөөрөөгүй хэвээр байна. УИХ-аас гүйцэтгэх засаглалд тавих хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх асуудал ч мөн хурцаар тавигдav. Энэ чиглэлд хийж буй эрэлхийллийн нэг нь 2008 оны 7 дугаар сарын 1-ний хэмээгдэх нээлттэй сонсгол болсон хэдий ч парламентын хяналтыг хэрэгжүүлэх үр нөлөөтэй арга замын нэг болох нээлттэй сонсгол журамлагдаж албажаагүй хэвээр л байна.

Тэрчлэн, иргэний нийгмийн байгууллагуудын өмнө урьд урьдаас

илүүтэй нийгмийн өмнө хүлээсэн үндсэн үүргээ гүнзгий ухаарч, цаг зуурын, амин хувийн, улс төрийн өнгө аястай, захиалгын хэлбэртэй үйлдлүүдээс анgid байж, нийтийн эрх ашгийн манаанд гүйвалтгүй зогсож, хүний эрх, ардчиллын үнэт зүйлсийг баримтлан төрийг тууштай, үр нөлөөтэй хянах сорилт тулгарлаа.

Дэлхийн санхүү, эдийн засгийн хямрал Монголд үргэлжлэн давалгаалж, юуны өмнө барилга, дэд бүтцийн салбаруудыг үндсэнд нь царцаан дампууруулж байхад байгаль, цаг уурын эргэлт буцалтгүй өөрчлөлтүүд газар тариалан, мал аж ахуйн салбарыг бүхлээр нь хамраасан онц хүнд жил байлаа. Банк, санхүүгийн тогтолцооны хямрал улам даамжираар байв. Үүнийг арилжааны хоёр ч банк дампуурснаас бэлхнээ харж болно. 2009-2010 оны үргэлжилсэн зуданд 8.1 сая мал хорогдж /2010 оны тавдугаар сарын байдлаар/, 80.000 малчин өрх амьжиргааны доод түвшинд шилжээд байна. Дуусаагүй барилгын нийт тоо 3300-д хүрч, энэ салбарт нийтдээ 400 тэрбум төгрөг эргэлтэд орж чадалгүй түгжигдсэнээр эдийн засгийн гол салбаруудын нэг үндсэндээ зогсонги, үхмэл байдалд орлоо. Газрын харилцааны согог илэрч, иргэдэд өмчлөгдсөн газар эдийн засгийн эргэлтгүй, үнэ цэнэгүй хэвээр үлдэж баялаг бүтээлцэх үүргээ гүйцэтгэж

чадсангүй. Төрийн албан хаагчдын орон сууцны хөтөлбөр нэрээр барилгын цөөн хэдэн компанид Засгийн газрын хөрөнгөөр дэмжлэг үзүүлсэн нь төдийлөн амжилттай арга хэмжээ, барилгын салбар хямралыг гатлахад дэмжлэг болж чадсангүй.

Дэлхий ертөнц эдийн засгийн хямралаас хөндийрөн сэхэхийн хамтаар эрчим хүчиний эх үүсвэр, түлшний эрэлтэд дулдуудсан ирээдүй, гэрэл гэгээ цөөхөн хүн амтай жижиг Монголыг өндийлгөх хүчин зүйлийг агуулж байна. Гагцхүү Монголын төр иргэддээ нээлттэй, ил тод, хариуцлагатай байж, олон зууны бэрхийг туулан энэхүү ховор завшаантай золгосон улс үндэстнийхээ нийтлэг эрх ашгийг эрхэмлэвээс байгалийн баялгийн хараалыг тойрч, хөгжлийн зам дээр гарахыг бидний өмнөөс төр барьж буй эрхмүүд ухаарч буй бизээ.

Удаан хугацаагаар хатуурхан хайрсан цаг агаарын хүнд нөхцөл байдал олон мянган малчин өрхийг маань нэрвэж, ядуурлын ирмэгт аваачиж цөлмөсөн ч хүн бүр, айл өрх бүр аливаад итгэж, тэтгэмж харж суухын оронд өөртөө найдаж, хөдөлмерийн хөлс хүчээр өөдөлдөг болохыг мэдэрсэн зөв цаг үе ирсэн гэдэгт бас итгэж байна. Төрд төсөвлөгдж, олон дахин давхардуулж

тооцогддог, бараг эргэлтгүй, тиймээс үр ашиг авчирдаггүй мөнгө, хөрөнгийн зарцуулалтын шинэчлэлийг хурдтай хийх суурь нөхцлүүд бүрдсэн байна.

Улс орны амьдралын энэхүү адармаатай нэгэн жилийн хэмнэлд Нээлттэй Нийгэм Форум маань өөрийн бодлого үйл ажиллагааны хүрээнд идэвхтэй оролцоотой байж тодорхой хувь нэмрээ оруулахаар чармайн ажиллалаа. Засаглал, эдийн засаг, нийгмийн салбарын тодорхой асуудлуудаар бидний хийж бүтээсэн, бүтээхийг оролдон зорьж явaa үйл хэргийн тухай ээлжит тайлан мэдээллийг Эрхэм танд толилуулж буйдаа таатай байна. Хэрэв Та Нээлттэй Нийгэм Форумаас хэрэгжүүлсэн, санаачилсан, санхүүжүүлсэн, иргэний нийгмийн бусад байгууллагатай хамтран гүйцэтгэсэн арга хэмжээ, үйл ажиллагааны талаар санал сэтгэгдлээ хуваалцах аваас бид талархан хүлээн авах болно.

*Нээлттэй Нийгэм Форумын
гүйцэтгэх захирал*

П.Эрдэнэжаргал



ЗАСАГЛАЛЫН ХӨТӨЛБӨР

Иргэний нийгмээс засаглалд тавих хяналтын тогтолцоо, иргэний мэдээлэл авах эрх чөлөө болон төрөөс авах үйлчилгээний хүртээмжийн хувь хэмжээнд төдийлөн ахиц гарагчийг байгаа нь улстөрчид, засаглалын хариуцлагын тогтолцоо супрах бас нэг үндсэн шалтгаан юм. Энэ үндсэн шалтгааныг төрийн эрх мэдэл хэт занхайж, төр бүхийг хуваарилагч, зохицуулагч болж хувиран, иргэний санаачилга, хувийн хэвшлийн идэвхитэй чанарыг дарангуйлах болсноос хайх хэрэгтэй бизээ. Төсвийн зардал данхайж, зах зээлд эргэлдэх бэлэн мөнгөний урсгалыг төр хэт зохицуулах болсон нь төрийн эрх мэдэл хэмжээлшгүй их болсны шалтгаан юм.

Хүний эрхийн түгээмэл зарчмууд алдагдаа л байна. Ядуурал, ажилгүйдэл хувь хүний эрх чөлөөг боох үндсэн хүлээс болж байна. Өмч хөрөнгөгүйгээс эрхээ хамгаалуулж чадахгүй, шүүхийн шийдвэр тэр бүр тэгш байж чадаагүйгээс хүний эрх зөрчигдсөөр байна. Шүүхийн хараат бус засаглалгүйгээр иргэдийн эрх чөлөөг эн тэгш хангах, хуульчлагдсан орчин дахь чөлөөт иргэдийн хамтын оршил боломжгүй байх болно.

Нийгэмд явагдаж буй олон чиглэлт, янз бүрийн агуулгатай үйл явцад үйлчилгээ үзүүлж буй төрийн үйл ажиллагаанд нэг хувь хүн, байгууллага хяналт тавьж, харилцан санаачилгатай хамтран ажиллах угаасаа боломжгүй. Үүнийг тухайн асуудлуудаар мэргэшсэн иргэний нийгмийн байгууллагууд л гүйцэтгэж чаддаг. Иргэний нийгмийн байгууллагуудад дэмжлэг туслалцаа үзүүлэх, хамтран ажиллах, нээлттэй хэлэлцүүлэг явуулахгүйгээр бат бэх бүтэцтэй, хатуу шударга байр суурьтай бүтцүүдийг бий болгох боломжгүй юм.

Төрийн эрх мэдлийн хэт төвлөрөл, хяналгүйн улмаас улбаалсан хариуцлагагүй байдлыг эцэслэх нэг арга нь иргэдийн мэдээлэл авах эрхийг баталгаажуулах, нэн ялангуяа хэвлэл мэдээллийн эрх чөлөөг бий болгох явдал юм. Ийм эрх чөлөөг хангаж чадахгүй, төр, захирагааны үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл хаалттай байгаагаас хэвлэл мэдээллийн хэрэгслүүд мөн хаалттай болж, нийтэд нэг талт, захиалгат мэдээллийг түгээдэг, төрийн хатуу механизмын гар хөл болон хэлбэржихэд нөлөөлж байна.

Хэвлэлийн хараат бус байдлын мониторинг зэрэг хөндлөнгийн судалгааг тогтмолжуулах, хэвлэл мэдээлэлд гарч буй мэдээллийн бодит байдлын үнэлгээг тогтмол өгөх тухай асуудлууд тулгамдсан хэвээр байна.

Төрийн эрх мэдлийн хэрэгжүүлэлтийг оновчтой, хариуцлагатай болгох үндсэн арга хэрэгсэл нь аль ч шатны сонгуулийг чөлөөтэй, хамааралгүй, шударга явуулдаг байх зарчим юм. Энэ бүгд нь сонгуулийг зохион байгуулах дэг журмаас эхлээд санхүүжилтийн ил тод байдал, сурталчилгааны тэнцвэртэй түгээлт болон сонгуульд оролцогч субъектуудын хуулийн хүрээнд баримтлах сахилга бат, сонгогчдын ил тод, үнэн бодит бүртгэл, иргэдийн сонгуулийн боловсролын тухай өргөн хүрээтэй асуудал агаад эдгээрийг бүрдүүлэхгүйгээр иргэний нийгмийн байгуулалтын бүх үе шат утга учиргүй байх болно.

ННФ дээр дурдсан асуудлуудыг “Засаглалын хөтөлбөр”-ийн хүрээнд авч үзэн тодорхой үйл ажиллагааг тогтмол, дэс дараатай хэрэгжүүлж буйг Та бүхэн дараах төслүүдээс үзэх боломжтой.

ХҮНИЙ ЭРХ

Нээлттэй Нийгэм Форум энэхүү хөтөлбөрийн хүний эрхийн мониторинг хамгаалал, төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлэх эрх зүйн туслалцаа зэрэг төслүүдийг хэрэгжүүлж байна.

Хүний эрхийн мониторинг хамгаалал

Нээлттэй нийгмийн үнэт зүйлсийн нэг болох хүний эрх, эрх чөлөөг хамгаалах асуудлыг Нээлттэй Нийгэм Форум үйл ажиллагаанд үргэлж тусгасаар ирлээ. 2008 оны Долдугаар сарын 1-нд Монголд зарласан онц байдал, түүнтэй холбоотой гарсан хүний эрхийн зөрчлүүд нь ННФ-ыг хүний үндсэн эрхийг хамгаалан хангах тал дээр бие даасан төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагатай байгааг нотлон харууллаа.

Онцгой байдлын үеэр байгуулагдсан Хүний Эрхийн Баримтуулалт, Хамгааллын Эвслийн үйл ажиллагаа 2009 онд үргэлжлэн нийтийг хамаарсан эмх замбараагүй байдлын үеэр бусдын эд хөрөнгө болон эрүүл мэндэд хохирол үзүүлсэн гэх хөргээр яллагдсан иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх өмгөөллийн баг ажиллуулж 60 гаруй хүнд өмгөөллийн туслалцаа үзүүллээ. Өмгөөллийн баг энэ хэргийн байцаан шийтгэх ажиллагаанд мөн ажиглалт хийж тайлан гаргасан бөгөөд 2009 оны 12 дугаар сард УИХ-ын Хүний Эрхийн Дэд Хорооны “Долдугаар сарын 1 – Хүний эрхийн зөрчил” нээлттэй сонсголд мэдээлэл хийж, үйл ажиллагааныхаа үр дүнг олон нийт, тэр дундаа УИХ-ын гишүүдийн анхааралд хүргэсэн байна.

Өмгөөлөгчдийн ажиглалтаас харахад Долдугаар сарын 1-ны гэх хэрэгт байцаан шийтгэх ажиллагааны үеэр хүний эрхэд халдсан олон зөрчил илэрч, түүнд прокурорын байгууллагаас хангалттай хяналт тавьж урьдчилан сэргийлж чадаагүй төдийгүй шүүхээс гагцхүү яллах талд ажилласан хэмээн дүгнэжээ. Иймээс цаашид НҮБ-ын хүний эрхийн түгээмэл хэлэлцүүлэгт илтгэл илгээх зөргээр олон улсын хүний эрхийн механизмуудыг ашиглах нь зүйтэй хэмээн тогтсон байна.

ННФ-ын тэтгэлгээр Глоб Интернэшнл ТББ байгууллага 2008 оны онц байдал зарласантай холбоотойгоор хэвлэл, мэдээллийн үйл ажиллагаанд хийсэн мониторингийн тайлангаа эцэслэн боловсруулж, жилийн дараа буюу 2009 оны Долдугаар сарын 1-нд олон нийт хэвлэл мэдээллийн хэрэгслээр танилцууллаа. Энэхүү тайлангаас үзэхэд онц байдлын үеэр дангаараа ажилласан Монголын Үндэсний Олон Нийтийн Радио, Телевиз нь төрийн шууд хараа хяналт дор нэг талын тэнцвэргүй мэдээллийг олон нийтэд түгээсэн байна.

ННФ хүний эрхийн талаарх мэдлэг, мэдээллийг түгээх зорилгоор АНУ-ын Харвардын Их сургуулийн Хүний Эрхийн Төвийг үндэслэгч,

профессор Хенри Ж.Стайнериг урьж "Хүний эрх, ардчиллын харилцан хамаарал: Монголын кейс" сэдэвт илтгэлийг 2009 оны есдүгээр сарын 17-нд зохион байгууллаа. Монголын

хүний эрхийн чиглэлээр ажилладаг хүмүүст зориулсан энэхүү илтгэл нь тулгамдсан асуудлаар мэдээлэл олж авах, санал солилцох боломж олгосон чухал үйл явдал боллоо.

Төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлэх эрх зүйн туслалцаа

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэгт Монгол Улсын иргэн нь Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл энэ эрхээ хамгаалулахаар шүүхэд гомдол гаргах, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах эрхтэй болохыг баталгаажуулсан байдаг боловч ядуу, орлого багатай, төлбөрийн чадваргүй иргэд энэ эрхээ тэр бүр эдэлж чадахгүй байна. Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын тоон мэдээнээс харахад 2009 оны байдлаар Монгол Улсад эрүүгийн хэрэгт холбогдсон ял эдэлж байгаа хүмүүсийн 70 орчим хувь нь боловсролын түвшин доогуур юмуу боловсролгүй, ажилгүй байна. Түүнчлэн сүүлийн жилүүдэд ядуурлын түвшин буурах биш харин ч нэмэгдэж байгаагийн улмаас төлбөрийн чадваргүй иргэдийн тоо улам ихэсч байна.

2003 оноос Нээлттэй Нийгэм Форумын санаачлан хэрэгжүүлж эхэлсэн төлбөрийн чадваргүй иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх шинэ тогтолцоог нэвтрүүлэх төсөл 2006 онд Үндэсний хөтөлбөр болон батлагдсан юм. Ийнхүү 2008 оноос эхлэн 21 аймаг 9 дүүрэгт нийт 30 эрх зүйн туслалцааны төв нээгдэн үйл ажиллагаа явуулж байна.

Нээлттэй Нийгэм Форум Хууль Зүй Дотоод Хэргийн Яам /ХЗДХЯ/-наас удирдан явуулж

буй эрх зүйн туслалцааны тогтолцооны шинэтгэлд арга зүйн хувьд бүх талын дэмжлэг үзүүлсээр ирлээ. Гэсэн хэдий ч шинэ тулгар энэ тогтолцоо нь өнөөгийн эрэлт хэрэгцээг бүрэн хангаж ажиллаж чадахгүй байгаа юм. 2009 оны хувьд үндэсний тогтолцоог улам боловсронгуй болгох, дотоод удирдлагын механизмыг сайжруулах, эрх зүйн туслалцааны төвийн ажилтан болон өмгөөлөгчдийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор тодорхой үйл ажиллагааг шат дараатай явууллаа.

Эрх зүйн туслалцааны төвийн өмгөөлөгчдөд төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөлөл үзүүлэхтэй холбоотой арга зүйн болон өмгөөлөгчийн ур чадварын сургалтыг ӨАБНУ-ын Квазулу Натал Их сургуулийн клиник сургалтын багш, Эрх Зүйн Туслалцааны Төвийн өмгөөлөгч профессор Робин Палмер явуулав. Түүнчлэн прокурорын байгууллага, Монголын Өмгөөлөгчдийн Холбооны сургагч багш нар болон Хууль Зүйн сургуулийн багш нарын тусламжтайгаар дотоодын хууль тогтоомжийн хэрэглээ, төлбөрийн чадваргүй иргэдийн дунд түгээмэл тулгардаг асуудлаар нэмэлт мэдээлэл олгох сургалтыг 2009 оны 10 дугаар сард Эрх Зүйн Туслалцааны Төв/ЭЗТТ/-ийн өмгөөлөгчид болон эрх зүйн ажилтнуудад зориулан зохион байгууллаа.

Төлбөрийн чадваргүй иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх үндэсний зөвлөлийн

үйл ажиллагааг жигдруулэх, удирдлагыг сайжруулах нь энэхүү тогтолцооны цаашдын тогтвортой хөгжилд ихээхэн ач холбогдолтой юм. Энэхүү зорилгын хүрээнд Үндэсний зөвлөлийн гишүүдийн төлөөллийг ӨАБНУ-ын Дурбан, Иоханесбург хотуудад суралцах аялалд явуулж, эрх зүйн туслалцааны тогтолцооны жигд ажиллагааг хэрхэн хангах, төвүүдийн үйлчилгээний хүртээмж үр дүнг хэрхэн нэмэгдүүлэх тал дээр мэдлэг мэдээлэл олгов. Төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга болон Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга нар оролцсон бөгөөд эрх зүйн туслалцааны чиглэлээр бие даасан эрх зүйн баримт бичиг боловсруулах чиглэлийг ХЗДХЯ-наас батлахад чухал үр дүнтэй арга хэмжээ боллоо. Түүнчлэн ЭЗТТ-ийн өмгөөлөгч болон Үндэсний зөвлөлийн ажлын албаны ажилтнууд Болгар улсад зохион байгуулагдсан олон улсын бага хуралд оролцож бусад улс орны туршлагаас суралцсан байна.

Орон нутаг дахь эрх зүйн туслалцааны төвүүд маш их ачаалалтай ажиллах болсон тул Хууль зүйн клиник төвийн оюутнуудыг дадлагын журмаар ажиллуулах удирдамжийг Отгонтэнгэр Их сургууль болон МУИС-ийн Хууль зүйн клиник төвийн багш нартай хамтран боловсруулж Үндэсний зөвлөлд хүргүүлснээр Хууль зүйн сургуулиуд, клиник төвүүдтэй хамтран ажиллах гэрээ байгуулагдаж эхэллээ.

Төлбөрийн чадваргүй иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх Үндэсний хөтөлбөрийн хүрээндээрх зүйн туслалцааны талаар бие даасан эрх зүйн баримт бичгийн суурь үндэслэлийг тодорхойлох зорилготой суурь судалгаа хийхэд зориулан ННФ болон НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрөөс Хууль Зүйн Үндэсний Хүрээлэнд дэмжлэг үзүүлж байна. Судалгааг 2009 оны 12

дугаар сард эхлүүлэв. Түүнчлэн 2009 оны 10 дугаар сард НҮБ-ын ХХ, ХЗДХЯ болон ННФ-ын хооронд гурван талт харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурж 2010 оныг дуусталх хамтын ажиллагааг баталгаажуулсан нь хөтөлбөрийн хэрэгжилтийг тогтвортой хангахад чухал алхам болсон юм.

Төлбөрийн чадваргүй иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн Эрх Зүйн Саначилга болон Хүний Эрх, Засаглалын Тэтгэлэгт хөтөлбөрүүд байнга дэмжлэг туслалцаа үзүүлж байна.

ШҮҮХИЙН ХАРААТ БУС БАЙДАЛ

Шүүхийн бие даасан, хараат бус байдлыг хангах нь дан ганц шүүх эрх мэдлийн хүрээний хэрэг бус, Монгол Улсын хөгжил, дэвшил, ардчилсан хөгжлийн түлхүүр асуудал учраас олон нийт, иргэний нийгмийн байгууллага, иргэн бүрийн оролцоо, хяналт нэн чухал юм. Нээлттэй Нийгэм Форум 2008 онд шүүхийн салбарын шинэтгэлд үнэлгээ өгөх

судалгааг хийлгэснээр шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх хөтөлбөрийг эхлүүлсэн бөгөөд 2009 онд шүүхийн шинэтгэлийн үйл явцад олон нийтийн оролцоог хангах, бодлого боловсруулагчдыг шаардлагатай судалгаа, дүн шинжилгээгээр дэмжих зорилго тавин ажиллалаа. Энэхүү зорилгын хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаанаас дурдвал:

Иргэний нийгмийн зүгээс тавих хөндлөнгийн хяналт ажиглалт:

- Төрийн бус байгууллагууд болон хууль зүйн клиник төвүүдтэй хамтран хуулиар хориглосноос бусад тохиолдолд шүүх хуралдаан олон нийтэд нээлттэй явагдаж, шударга шүүхийн стандартуудыг даган мөрдөх байгаа эсэхэд ажиглалт хийх арга зүйг Польшийн Хүний Эрхийн Хельсинки Сангийн зөвлөх Лукаш Боярскийн дэмжлэгтэйгээр боловсруулж, хууль зүйн сургуулийн оюутнууд, хөдөө орон нутгийн иргэний нийгмийн төлөөллөөс бүрдсэн ажиглагчдын багийг сонгон шалгарууллаа. “Шүүхийн ажиглалт” төслийн үндсэн зорилго нь шүүхийн практикт олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрхийн стандартуудыг хэрхэн мөрдөж байгаад иргэдийн зүгээс хяналт тавих механизмыг бий болгоход чиглэж байна.
- ННФ-ын Мониторингийн тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд шүүх хуралдаан дахь иргэдийн төлөөлөгчдийн оролцоонд Хууль-Хүний Эрх Төв ТББ мониторинг хийлээ. Мониторингийн тайлангаас үзэхэд шүүн таслах ажиллагааны хууль ёсны байдал, талууд эрх тэгш оролцож шүүх хуралдааны нээлттэй болж буй эсэх, иргэдийн төлөөлөгчдийг сонгох, томилох үйл явц нь бүрхэг, төлөөлөгчдийн үүрэг тодорхойгүй байгаа нь шүүн таслах үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих явдлыг алдагдуулж байна.

Судалгааны ажлууд:

- ННФ-ын Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд “Монгол Улсад Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь”

сэдэвт бодлогын судалгааг МУИС-ийн ХЗС-ийн профессор, доктор Н. Лүндэндоржийн ахалсан баг хийж гүйцэтгэлээ. Судалгаагаар

шүүхийн хараат бус байдлыг шүүгчийн хараат бус байдалтай холбон авч үзэж, шүүхийн тогтолцоо, хууль эрх зүйн хүрээнд дүн шинжилгээ хийж бодлогын зөвлөмж боловсрууллаа.

Чингэхдээ шүүхийн хараат бус байдлыг хангах асуудлыг гурван түвшинд авч үзсэн бөгөөд нэгд, шүүх засаглал нь гүйцэтгэх болон хууль тогтоох засаглалаас хараат байгаа эсэх, хоёрт, захиргааны удирдлагын хүрээнд доод шатны шүүх дээд шатны шүүхээс хараат буй эсэх, гуравт, шүүгч хувь хүний хувьд хараат бус байх боломжоор хангагдсан, мэргэжлийн ёс зүйтэй байгаа эсэхийг судалжээ. Судалгааны тайланд шүүх засаглал, шүүх, шүүгч нь хараат бус байх тогтолцооны болон хувь хүний хүчин зүйлс нь дутмаг байна гэж дүгнэв. Тэрчлэн шүүхийн захиргааны болон шүүн таслах чиг үүргийг салгах, шүүхийн талаарх эрх зүйн зохицуулалтыг шинэчлэн сайжруулах

талаар тодорхой зөвлөмжүүдийг санал болголоо.

- Шүүхийн шинэтгэлийн үйл явцад бүрэн хэмжээний үнэлгээ хийх судалгааг ННФ-ын захиалгаар ШУА-ийн Философи Эрхийн Хүрээлэнгийн захирал доктор, профессор Ж.Амарсанаагийн удирдсан баг хийж дуусгав. Энэхүү судалгаа нь шүүхийн салбарын шинэтгэлийн явцыг цогцоор нь харах боломжийг түүнд оролцогчид, ялангуяа бодлого боловсруулагчдад олгосноороо чухалач холбогдолтой болсон юм. Судалгаагаар шүүхийн шинэтгэл нь дэд бүтцийн болон шүүгч, хуулийн байгууллагын ажилтнуудын сургалтын бааз суурийг бий болгоход ихээхэн амжилт гаргасан боловч тус салбарын эрх зүйн зохицуулалт, нээлттэй ил тод байдал, хариуцлагын механизмд хангалттай шинэтгэл авчирч чадаагүйг харуулжээ.

ТӨРИЙН ИЛ ТОД, ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДАЛ, ИРГЭНИЙ НИЙГМИЙН ОРОЛЦОО

Сайн засаглалын үндсэн зарчим нь ил тод, хариуцлагатай байдал бөгөөд энэ зарчим бодитой хэрэгжин биелэхэд эрх зүйн таатай орчин бүрэлдсэн байх ёстойгоос гадна төрийн байгууллага, иргэдийн аль алины нь чадавхи, идэвхи оролцоо чухал үүрэгтэй байдаг. Нээлттэй Нийгэм Форум байгуулагдсан цагаасаа эхлэн төрийн үйл ажиллагааны ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж,

төрийн байгууллагаас мэдээлэл авах иргэдийн эрхийг баталгаажуулах, хууль, шийдвэр гаргах үйл явцад иргэд оролцох механизмыг бий болгох, бодлого, шийдвэрийн биелэлт болон төрийн үйлчилгээнд хяналт тавих төрийн бус байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх, төрийн бус байгууллагуудын хөгжлийг дэмжих эрх зүйн орчныг боловсронгуй болгох зэрэг тодорхой асуудлуудад анхаарлаа хандуулан ажиллаж ирлээ.

Төрийн бус байгууллагуудын төрийн үйлчилгээнд тавих хяналт, мониторинг

Нээлттэй Нийгэм Форумын 2005 оноос эхлэн хэрэгжүүлж буй нэг чухал санаачилга бол төрийн ил тод, хариуцлагатай байдлыг хангахад иргэний нийгмийн гол бүрэлдэхүүн хэсэг болох төрийн бус байгууллагуудын хөндлөнгийн хяналт тавих чиг үүргийг нэмэгдүүлэх, тэдний чадавхийг бэхжүүлэх зорилго бүхий мониторингийн тэтгэлэгт хөтөлбөр юм. 2009 онд уг хөтөлбөрт 24 байгууллага оролцож, төсвийн ил тод байдал, зарцуулалт, шүүхийн үйл ажиллагааны ил тод байдал, нийгмийн халамжийн болон боловсролын салбарын үйлчилгээнд мониторинг хийхийн сацуу тулгамдаж буй асуудлуудыг засч залруулахад чиглэсэн үйлажиллагаагамжилттай хэрэгжүүлж чамгүй үр дүнтэй ажиллажээ. Эдгээрээс жишээ болгон дурдвал ИРИМ ТББ Баянзүрх дүүргийн төсвийг хэлэлцэн батлах үйл явцад иргэдийг оролцуулах загвар боловсруулан туршиж, гарын авлага бэлтгэн гаргав. Хөдөөгийн Эмэгтэйчүүдийн Хөгжлийг Дэмжих Сангийн Өмнөговь аймгийн салбар зөвлөл “Ил тод нөөц” төслийн хүрээнд засаг даргын нөөц сангийн зарцуулалтад мониторинг хийж, хөрөнгийг үр ашигтай зарцуулах, зориулалт, хяналтыг тодорхой болгох талаарх заалтуудыг нөөц сангийн зарцуулалтын журамд нэмж тусгусан байна. Эмэгтэй Удирдагч Сан ТББ Чингэлтэй дүүргийн тохижилтийн гэрэлтүүлэг, ногоон бус байгуулахад зарцуулж буй төсөвт мониторинг хийж, төсвийн хөрөнгөөр хийгдсэн ажил чанаргүй, үр дүн нь ядмаг, тендерийн болон төсвийг тайлагнах байдал ил тод бус байгааг илрүүлж, цаашид төсвийн ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр УИХ-ын зарим гишүүн, “Иргэд Төсвөө Хянана” сүлжээтэй хамтран ажиллаж байна.

Хөтөлбөрийн хүрээнд ННФ уламжлал ёсоор оролцогч ТББ-уудад зориулж мониторингийн арга зүйн цуврал сургалт хийж, төсөл хэрэгжүүлэх явцад нь байнга зөвлөгөө, туслалцаа үзүүлсэн болно. Түүнчлэн ТББ-ууд хоорондоо туршлага солилцох, хамтран ажиллахад нь нэмэлт дэмжлэг үзүүлсний зэрэгцээ тайланг хэвлэн нийтийн хүртээл болголоо.

Цаашид мониторинг хийх чадавхитай ТББ-уудын тоог улам нэмэгдүүлэх, ялангуяа хөдөө орон нутгийн ТББ-уудыг хөтөлбөрт татан оролцуулах, тодорхой салбар чиглэлд мониторинг хийж мэргэшиж буй байгууллагууд, тэдний үүсгэн байгуулсан сүлжээний үйл ажиллагаанд дэмжлэг туслалцаа үзүүлэн бүсийн болон олон улсын ижил төстэй байгууллагуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох боломжоор хангахад анхааран ажиллана.

Хөтөлбөр хэрэгжсэн таван жилийн хугацаанд нийслэлд болон үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй байгууллагууд илүүтэй хамрагдсан бол сүүлийн хоёр жилд хөдөөгийн зарим аймагт мониторингийн арга барил эзэмшсэн ТББ-ууд хамтран идэвхтэй үйл ажиллагаа явуулж эхэлсэн нь нааштай үр дүн юм. Түүнчлэн 2009 оноос эхлэн төрд хөндлөнгийн хяналт тавих чиглэлээр ажиллаж буй байгууллагуудын оролцоог үнэлэн дэмжлэг үзүүлэхэд Монголд ажиллаж буй донор байгууллагууд, тухайлбал Дэлхийн Банк, Швейцарийн Хөгжлийн Агентлаг анхаарлаа хандуулах болсон нь ТББ-уудын үйл ажиллагаанд ахиц авчирч байна.

ГАЗАР ОЛГОЛТЫН МОНИТОРИНГ

Туул голын ай сав дахь Цагаан арал хэмээн газарт "Аялал жуулчлал, гольфын талбайн зориулалт"-аар 50 га газар ашиглах зөвшөөрлийг Баянзүрх дүүргийн Засаг дарга 2007 оны тавдугаар сарын 9-ний өдөр 130 дугаар захирамжаар "Туул ривэр контри сайд" компанид олгожээ. Энэ захирамж нь гольфын талбайн байгаль орчин, ундны усны чанарт үзүүлэх нөлөөг тооцоолоогүй хийгдсэн гэж үзэн газар олголт хуулийн дагуу явагдсан эсэхийг тодруулах зорилгоор Хүүхдэд Экологийн Боловсрол Олгох ТББ, Туул Голоо Хамгаалах Хөдөлгөөнтэй хамтран 2009 оны 1-10 дугаар сард мониторинг хийсэн болно.

Туул бол Хан Хэntийгээс эх авч таван аймгийн 11 sumaар дамжин өнгөрч Орхон голд цутгадаг 704 км урт гол бөгөөд Улаанбаатар хотын сая гаруй иргэний ундны усны эх үүсвэр юм. Гольфын талбайг байгуулж ашиглахад дунджаар 107 нэр төрлийн химийн бодис ашигладаг бөгөөд усны сав газар, хагалбар газар байгуулдаггүй олон улсын жишиг байдаг. Шинэ Зеланд улсад гольфын талбай байгуулахад орон нутгийн удирдлагын тухай хууль, байгалийн баялгийг хамгаалах, мөхөж болзошгүй болон шинэ төрөл зүйлийн амьд биетийг хамгаалах гэсэн гурван хуулийн зүйл заалтыг чанд мөрддөг аж. Бордоо, пестицид зэрэг химийн бодис, гольфын талбайн машин, бөмбөг, байр савны цэвэрлэгээний уусмал нь гадаргын болон гүний усиг бохирдуулдаг тул Канад улсад байгаль хамгаалах зорилгоор усны ургамал, амьтдад үзүүлж буй нөлөөнд тогтмол мониторинг хийхийг шаарддаг байна.

Мониторингийн дүнд:

1. Баянзүрх дүүргийн Засаг даргын 130 дугаар захирамж нь НИТХ-ын 2006 оны 12 дугаар сарын 19-ний 9/48 дугаар тогтоолоор батлагдсан Баянзүрх уулын ар хормойд аялал жуулчлалын зориулалтаар 4 га газар олгох төлөвлөгөөг зөрчиж байршил, газрын хэмжээг өөрчилсөн болохыг тогтоосон байна.
2. Газрын зөвшөөрлийг "Туул ривер контри сайд" нэrtэй 100 хувийн гадаадын хөрөнгө оруулалттай компанид байгуулагдахаас нь 28 хоногийн өмнө төдийгүй газар ашиглахыг хүссэн ямар нэгэн бичиг баримтгүйгээр олгосон болохыг баримтаар нотолжээ.
3. Монгол Улсад одоогоор гольфын талбай байгуулах эрх зүйн орчин бүрдээгүй, тодорхой жишиг байхгүй ч аливаа зорилгоор газар ашиглахдаа байгаль орчны үнэлгээ, төлөвлөлт хийж холбогдох яамдаар батлуулах хуулийн заалт бий. "Туул ривер контри сайд" компанийн байгаль орчны нарийвчилсан үнэлгээг үзэхэд усны шинжилгээ нь Шарын голын усны шинжилгээний дүng хуулсан, цэвэрлэх байгууламжийн үндэслэл байхгүй, гидробиологи тодорхой бус, судалгаа шинжилгээ, зураг баримтгүй, байгаль хамгаалах арга, түүнд шаардагдах төсөв зэрэг бүлгүүд ор нэр төдий хангалтгүй хийгдсэн, зүлэг усны хэмжээг тогтоогоогүй зэрэг олон зөрчил илэрчээ. Түүнчлэн гол гатлах гүүр тавилгүй хөрс хуулалтын ажлыг эхлүүлсэн тул хүнд машин механизм голын усиг бохирдуулж байлаа.

Мониторингийн нөлөөллийн үйл ажиллагааны хүрээнд Засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хуулийн дагуу Баянзүрх дүүргийн Засаг даргын захирамжийн холбогдох заалтыг хүчингүй болгуулахаар Нийслэлийн Засаг даргад хандсан боловч тодорхой хариу өгөөгүй учир Нийслэлийн захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гарган улмаар дээрх захирамжийн холбогдох заалт нь Газрын тухай хуулийн 31.2, 32.1, Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 12.8.2, 12.8.3, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн 11.2, 15.1 дүгээр заалтуудыг зөрчсөн болохыг тогтоолгосон болно. Үүний дараа давж заалдах шатны шүүх, Дээд шүүхийн хяналтын шатны шүүхээс Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг баталсан шийдвэр гаргасан байна.

Эцэст нь 2009 оны 8, 9 дүгээр саруудад Ус Сувгийн Удирдах Газар Японы судлаачидтай хамтран Цагаан эрэгт 15 метрийн гүнд асар их хэмжээний цэвэр усны нөөц байгааг илрүүлж Японы Засгийн газрын 30 сая долларын буцалтгүй тусламжаар Нийслэлийн ундны цэвэр усны тавдахь эх үүсвэрийг барих шийдвэр гараад байна.

Төр бус байгууллагуудын хөгжлийг дэмжих эрх зүйн орчин

Нээлттэй Нийгэм Форум төрийн бус байгууллагуудын нийгэмд үзүүлэх үр нөлөөг нэмэгдүүлэх, тогтвортой хөгжлийг хангах эрх зүйн таатай орчныг бий болгох асуудлыг байнга анхаарч ирлээ. 2009 онд Хууль Зүй Дотоод Хэргийн Яамнаас Төрийн бус байгууллагын тухай хуулийг шинэчлэх ажлын хэсэг байгуулсан бөгөөд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ННФ оролцон хуулийн төслийн шинэчилсэн найруулгыг боловсруулахад мэргэжлийн санал зөвлөмж нэмэрлэв.

2009 оны 11 дүгээр сарын 19-нд Нээлттэй Нийгэм Форум Ардчиллын төлөө дэлхийн хөдөлгөөн, Ашгийн бус байгууллагын тухай хуулийн олон улсын төв, МОНФЕМНЕТ, Ардчиллын боловсрол төв байгууллагуудтай хамтран "ТББ-ын хөгжлийг дэмжих эрх зүйн

шинэчлэл" сэдэвт уулзалт зохион байгуулж Монголын төрийн бус байгууллагуудад тулгамдаж буй асуудлууд, эрх зүйн орчинд шаардлагатай байгаа өөрчлөлтүүд хийгээд ХЗДХЯ-ны боловсруулсан дээрх төслийн талаар өргөн хүрээтэй хэлэлцүүлэг өрнүүллээ. Хуралдааны эцэст ТББ-ууд болоод гадаадын мэргэжилтнүүдийн гаргаж дэвшүүлсэн санал санаачилгыг тусган Д. Ламжав тэргүүтэй иргэний нийгмийн ажлын хэсэг 1997 онд батлагдсан Төрийн бус байгууллагын тухай хуулийг ХЗДХЯ-ны хувилбараас арай өөр байдлаар шинэчлэн найруулсныг ХЗДХЯ-нд хүргүүлээд байгаа бөгөөд хуулийн төслийн ажлын хэсэг одоогоор УИХ-д өргөн барих эцсийн хувилбарыг боловсруулж байна.

Иргэдийн оролцоо ба мэдээллийн эрх чөлөө

Манайд өнөөг хүртэл бодлогын үйл явцад иргэд, төрийн бус байгууллагуудын оролцох арга зам нь захидал бичих, албан бус уулзалт зөвлөгөөн зохион байгуулах, хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт оролцох төдийгөөр хязгаарлагдааар иржээ. Хууль тогтоох үйл явцын ил тод байдлыг хангах, иргэд УИХ-аас сонирхсон асуудлаараа мэдээлэл авч хууль боловсруулах, хэлэлцэх явцад оролцох боломжийг бий болгох хэрэгцээ, шаардлага тулгамдсан хэвээр байна. ННФ хууль боловсруулах, батлах үйл явцын ил тод байдлыг хангах, иргэдийн болон төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэхэд чиглэгдсэн хууль эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, өөрийн нөхцөл байдалд тохирсон загварыг олж сонгоход дэмжлэг үзүүлэх санаачилгыг дэс дараатай хэрэгжүүлж байгаа юм.

Монгол Улсын иргэд Үндсэн хуулиар олгогдсон эрхийнхээ дагуу төрөөс гаргаж буй бодлого шийдвэрийн талаар санал шүүмжлэл, байр сууриа илэрхийлэн оролцох үр дүнтэй суваг механизмын нэг болох нээлттэй сонсгал гэж юу болох, түүнд хэрхэн оролцох талаарх гарын авлагыг НФФ 2009 онд эрхлэн гаргалаа. Нээлттэй сонсгал нь парламентын үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, иргэдэд ашиг сонирхлыг нь хөндсөн аливаа асуудлаар байр суурь, үзэл бодлоо илэрхийлэн оролцох боломж олгодог нээлттэй үйл явц юм. 2009 оны 12 дугаар сард Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэд нээлттэй сонсгал зохион байгуулан иргэд, байгууллагуудаас санал хууль, дүрэм журам, шийдвэрүүдийн төсөлд санал шүүмж авах зорилгоор Иргэний танхимыг нээн ажиллуулж эхлэв. ННФ энэхүү шинэ арга механизмыг амжилттай хэрэгжүүлж хэвшүүлэхэд дэмжлэг болгон Иргэний танхимын үйл ажиллагаанд арга зүйн болон

техникийн туслалцаа үзүүллээ. Тухайлбал, Иргэний танхимиын журмын төсөлд тодорхой санал, шүүмж боловсруулж танилцуулсан нь уг журамд тусгалаа олсон байна. Түүнчлэн иргэний танхимд болох сонсголыг удирдан явуулах хүмүүст арга зүйн зөвлөгөө өгөх зэргээр хамтран ажиллалаа.

Цаашид ард түмнээс шууд сонгогдсон, тэдний хүсэл зоригийн илэрхийлэл байж төрийг удирдах үүрэгтэй Монгол Улсын Их Хурал нь хууль боловсруулах, хэлэлцэх үйл явцдаа иргэдийн дуу хоолой, санал бодлыг сонсч тусгадаг болох хэрэгцээ шаардлага хэвээр байна. Өмнөх УИХ-ын үед энэ чиглэлийн холбогдох хуулиудад өөрчлөлт оруулах асуудал яригдаж байсан ч шийдвэрлэгдээгүй өнөөг хүрчээ. ННФ хууль тогтоох үйл явцын ил тод байдлыг хангах, иргэд мэдээлэл авч оролцох байнгын тогтмол үйл ажиллагаатай механизмыг бий болгох талаар УИХ-тай хамтран ажиллахаар төлөвлөж байна.

Түүнчлэн иргэний нийгмийнхний олон жилийн хичээлзүтгэлийнүүрдүндбийболсон Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл УИХ-д өргөн баригдсан ч батлагдахгүй байсаар хэдэн жил өнгөрчээ. Хуулийн төслийг энэ гацаанаас гаргахад шаардагдах судалгаа шинжилгээ, тухайлбал иргэдийн мэдээлэл авах эрх, эрх чөлөөг хангах зорилгод нийцүүлэн нууцын холбогдолтой хууль тогтоомжийг шинэчлэх, мэдээллийн эрх чөлөөг хуульчилсан орнуудад нууцын холбогдолтой ямар зохицуулалтууд байдгийг (төр иргэдээсээ нууцалж болох мэдээллийн жагсаалтыг гаргахад ашигладаг аргачлал) судлахын зэрэгцээ олон улсын ерөнхий хандлага, нийтлэг жишигийг судлан Монголын нөхцөлд тохиромжтой, оновчтой бодлогын хувилбар боловсруулах ажлыг ННФ-ын бодлогын судалгааны хөтөлбөрийн хүрээнд хийхээр төлөвлөж байна.

Стратегийн өмгөөлөл

Стратегийн өмгөөлөл нь төрийн хариуцлагатай байдлыг дээшлүүлэхэд иргэний нийгмийн зүгээс хэрэглэдэг үр дүнтэй арга хэрэгсэл бөгөөд Монголын иргэний нийгмийн байгууллагууд өөрийн үйл ажиллагаандаа хэрэгжүүлж хэвшиг нь нэн ач холбогдолтой билээ. ННФ 2006 оноос эхлэн олон улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг Нью-Йорк хотноо төвтэй Нийтийн Эрх ашгийн Эрх зүйн Институт байгууллагатай хамтран стратегийн өмгөөллийг ТББ-уудад танилцуулах, мэдлэг туршлага түгээхэд тэргүүлэх үүрэг гүйцэтгэж байна.

2009 онд ТББ-уудын дунд цуврал уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулж, стратегийн өмгөөлөл явуулах боломж, тулгарч буй бэрхшээлийг нэлээн өргөн хүрээнд тодорхойлсон болно. Тэрчлэн стратегийн өмгөөллийн ойлголт, туршлагыг улам бэхжүүлэх, ТББ-ууд, хуульч өмгөөлөгчдийн

хамтын ажиллагааг бий болгох зорилгоор тэтгэлэгт хөтөлбөр зарласан бөгөөд Монголын Байгаль Хамгаалах Иргэний Хөдөлгөөнүүдийн Эвсэл, Монголын Байгаль Орчны Төлөөх Хуульчдын Холбоо, Монголын Хуульч Эмэгтэйчүүдийн Холбоо, Зориг Сан, Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв зэрэг таван байгууллага хүний эрх, олон нийтийн эрх ашгийг хөндсөн асуудлаар стратегийн өмгөөллийн үйл ажиллагаа явуулж эхэллээ.

Стратегийн өмгөөлөл хийх зорилтой ТББ, өмгөөлөгчдөд зориулан аргачлал, зөвлөмж бүхий гарын авлага боловсруулан гаргалаа. Гарынавлаганьстратегийнөмгөөллийнпрактик туршлага, сургамжид тулгуурласнаараа 2003 оны гарын авлагаас ялгаатай юм. Стратегийн өмгөөллийн сайн туршлагын талаар кейс боловсруулж, цуврал сургалт хийх бэлтгэл ажлыг зохион байгууллаа.



ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ

Улс оронд болж буй үйл явдлын тухай үнэн бодит мэдээлэл авах эрх иргэдэд бий. Гэтэл хэвлэл, мэдээллийн хэрэгслийг өөрийн дуу хоолой, ухуулга сурталчилгаа, суртал нэвтрүүлгийн хэрэгсэл болгон ашиглаж, нийгэмд ноёрхол, нөлөөгөө тогтоох хүсэл эрмэлзэл, ашиг сонирхол бүхий улстөрч, эрх мэдэлтэн, бизнесийн бүлэглэлүүд зонхilon эзэмших болж, төлбөртэй, захиалгатай мэдээлэл нэмэгдэн, сэтгүүл зүйн мэдээний агуулгад ч сөргөөр нөлөөлж эхэлснээр иргэдийн цензургүй, хараат бус, үнэн мэдээлэл авах боломж улам хумигдсаар байна.

Нээлттэй Нийгэм Форум Лондон дахь Хэвлэл Мэдээллийн Хэрэгслийн Сүлжээ хөтөлбөртэй хамтран Глоб Интернэшнл ТББ-ын "Үзэл бодлоо илэрхийлэх эрхийн мониторинг, хараат бус хэвлэл мэдээллийн эрхийг дэмжих нь" төслийг дэмжиж арга зүйн туслалцаа үзүүлэн ажиллалаа. Төсөл нь олон нийтийн цензургүй, чөлөөт мэдээлэлтэй байх эрхийг хөхиүүлэн дэмжсэнээр Монголын ардчилал, ил тод байдалд хувь нэмэр оруулах зорилготой бөгөөд сэтгүүлчдийн мэргэжлийн эрхийн зөрчилд мониторинг хийх, хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын тогтолцоог дэмжих үйл ажиллагаа явуулж байна. Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 60 жилийн ой, Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдөр, Долдугаар сарын нэгний үйл явдлыг тохиолдуулан 155 хүнийг шууд хамруулсан гурван хэлэлцүүлэг өрнүүлж, хэвлэлийн эрх чөлөө, хараат бус хэвлэл, сэтгүүлчдийн мэргэжлийн эрхээ эдлэхэд тулгарч буй бэрхшээлийн тухай авч хэлэлцлээ.

Төслийн явцад хэвлэл, мэдээллийн хараат бус байдалд халдах, мэргэжлийн ажил үргээ гүйцэтгэж буй сэтгүүлчдэд шахалт үзүүлэх, айлан сүрдүүлэх, заналхийлэх, төрийн байгууллага сэтгүүлчдэд мэдээлэл өгөхөөс татгалзах, мэдээллийн нууц эх сурвалжаа илчлэхийг шаардах, дарамтлах зэргээр мэргэжлийн эрх нь зөрчигдсөн 79 тохиолдол бүртгэгджээ. Болзошгүй дарамтаас сэргийлэх, өөрийн эрхийн зөрчлийн тухай нийтэд мэдээлэхийг хүсдэггүй сэтгүүлчдийн тоо ч нэмэгдэж байна.



Сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаанд саад учуруулагсдын дийлэнх нь эрх мэдэлтэн, төрийн албан тушаалтан байдаг. Ялангуяа шүүмжлэлд өртсөн албан тушаалтнууд нэр төрөө сэргээлгэхээр хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлчдийн эсрэг иргэний, эрүүгийн хэрэг үүсгэн дарамтлах нь элбэг тохиолддог. Төслийн хүрээнд хийсэн судалгаанаас үзэхэд жилд 30 гаруй ийм хэрэг шүүхээр шийдвэрлэгддэг байна. Сэтгүүлчдийн мэргэжлийн эрхийн хамгаалалт хангалтгүй байгаа тул тэдэнд үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх, иргэний, эрүүгийн хэрэгт өмгөөлөгчөөр хангах зэрэг эрх зүйн туслалцааг төслийн хүрээнд үзүүлэв. Тухайлбал, Өвөрхангай, Завхан аймгийн сэтгүүлчидтэй холбоотой хэрэг дээр ажиллаж Дээд Шүүхэд прецедент тогтоосон байна. Албан тушаалтны үйлдэл, дарамт, цагдан хяналт, хууль зөрчсөн тухай нийтэд мэдээлж, эсэргүүцэл илэрхийлэх нь сэтгүүлчдийн хараат бус байдлыг хангах, хэвлэл мэдээллийн хэрэгслийн нийгмийн хоточ нохой болох үүргээ биелүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Сэтгүүлчдийн мэргэжлийн эрхийг хамгаалах нэг хэлбэр нь эсэргүүцлийн захидал, хэвлэлийн мэдээ, нээлттэй мэдээлэл байдаг. Төслийн хугацаанд эрхийн зөрчлийн тухай мэдээллийг он-лайн сонин бичиг, вэб сайт, мөн үзэл бодлоо илэрхийлэх олон улсын байгууллага болох IFEX-ийн сүлжээгээр түгээлээ. Сэтгүүлчдийн мэргэжлийн эрхийн зөрчлийг илрүүлж мэдээлэх нь иргэд цензургүй мэдээлэл авах эрхээ өдлэх, олон янзын ашиг сонирхлын нөлөөгөөр гажуудсан мэдээллээр олон нийтийг төөрөгдүүлэхээс сэргийлэхэд ч мөн чухал ач холбогдолтой.

Хэвлэл, мэдээлэл өөрийгөө удирдах, өөрийгөө зохицуулах, өөрийгөө хянах нь ёс зүйт, хариуцлагатай, хараат бус хэвлэл мэдээллийн эрх чөлөөний баталгаа юм. Иймд хэвлэл, мэдээллийн өөрийн зохицуулалтын мөн чанар, зарчим, санхүүжилтийн тухай мэдлэг олгох, гадаадын тэргүүн туршлагыг дэлгэрүүлэх зорилгоор хэвлэл мэдээлэл, сэтгүүл зүйн 10 мэргэжилтнээс бүрдсэн багийн тусlamжтайгаар “Хэвлэлийн өөрийн зохицуулалт” гарын авлагыг бэлтгэн, Монголын сэтгүүлчдийн гуравны нэгт түгээлээ.



ЧӨЛӨӨТ ШУДАРГА СОНГУУЛЬ

Иргэдийн сонгох, сонгогдох эрхийн баталгааг хангасан чөлөөт, шударга сонгуулийг явуулахад Нээлттэй Нийгэм Форум байнга анхаарч, сонгуулийн үйл явцыг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох, сонгогчдын нийтлэг эрх ашгийг төлөөлөн хяналт тавих иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн идэвхтэй үйл ажиллагаа явуулж ирлээ.

2009 онд болсон улс төрийн чухал үйл явдлын нэг нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль юм. Энэхүү сонгуулийг угтсан нийгмийн уур амьсгал нь 2008 оны УИХ-ын сонгуулийн гашуун туршлага давтагдах вий гэсэн сэрэмжлэл, зөрчил маргаан бага гараасай гэх

иргэдийн найдлага, хүлээлтээр дүүрэн байлаа. Түүнчлэн УИХ-ын сонгуулийн дараахан болсон орон нутгийн сонгуулиар нийслэлийн зарим дүүрэгт сонгогчдын ирц хуулиар тогтоосон хувь хэмжээнд хүрээгүй явдал дахин тохиолдох вий гэсэн болгоомжлол ч ажиглагдаж байв.

ННФ Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр өмнөх сонгуулиудын туршлагад үндэслэн зөрчил маргаанаас сэргийлэхэд гол нөлөөтэй гэж үзсэн хэд хэдэн чиглэлээр сонгуулийн үйл явцад бие даасан, хөндлөнгийн хяналт тавих ажлыг “Шударга Сонгуулийн Төлөө Иргэний Нийгмийн Хяналт Сүлжээ”-тэй хамтран хэрэгжүүллээ. Тус Сүлжээ нь 2008 оны тавдугаар

сарын 14-нд Нээлттэй Нийгэм Форумын санаачилгаар сонгуулийн үйл явцын ил тод байдлыг сайжруулах, иргэний нийгмийн хяналт, оролцоог хангах зорилготой байгуулагдсан юм. Энэ удаагийн Ерөнхийлөгчийн сонгуульд Сүлжээний зүгээс ННФ-ын дэмжлэгтэйгээр доорх гурван чиглэлээр хяналт тавьсан бөгөөд үүнд ТББ-ын мэргэжилтнүүд, оюутан, сайн дурынхнаас бүрдсэн 100 гаруй хүн хүчин зүтгэж оролцлоо.

Сонгууль бүрээр хамгийн их маргаан дагуулдаг сонгогчдын нэрийн жагсаалтад анх удаа мониторинг хийх ажлыг Сүлжээний гишүүн Филантропи Хөгжлийн Төлөө Төв ТББ 2008 оны УИХ-ын сонгуулийн үеэр зохион байгуулсан. Уг мониторингоор сонгуулийн зөвхөн нэг тойргийн хэмжээнд сонгогчдын нэрийн жагсаалтад насанд хүрээгүй болон нас барсан, хорих ял эдэлж байгаа болон огт байхгүй хаяг дээр хүмүүс бүртгэсэн зэрэг хэдэн мянган зөрчил байгааг олж илрүүлсэн боловч тухайн үед сонгуулийн хороод зөрчлийг арилгах талаар дорвitoй арга хэмжээ авалгүй өнгөрсөн юм. Ерөнхийлөгчийн сонгуулиар сонгогчдын нэрийн жагсаалтад байгаа дээрх зөрчлийг нэг мөр арилгуулж мониторингийн үр дүнг баталгаажуулах зорилго тавин Баянзүрх дүүргийн хэмжээнд сонгогчдын нэрийн жагсаалтыг дахин хянаж нягтлах ажилд ННФ дэмжлэг үзүүлж оролцов. Энэ нь нийслэлийн хамгийн их хүн амтай дүүрэгт сонгуулийн гол баримт бичиг болох сонгогчдын нэрийн жагсаалтыг үнэн бодитой гарахад тодорхой нөлөө үзүүлсэн ач холбогдолтой үйл ажиллагаа боллоо.

Түүнчлэн ардчилсан сонгуулийн үеэр хэвлэл, мэдээлэл нь үзэл бодлын чөлөөт индэр болж, нэр дэвшигч, улс төрийн нам, эвслийн байр суурийг олон нийтэд ойлгуулах, зөв сонголт

хийхэд туслах үүрэгтэйг харгалzan ННФ сонгуулийн үеэрхэвлэл, мэдээллийн тэнцвэртэй байдалд мониторинг хийхэд Сүлжээний гишүүн байгууллага Глоб Интернэшнл ТББ-д дэмжлэг үзүүллээ. Мониторингийн дүн, дүгнэлтийг үндэслэн Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг улам боловсронгуй болгох, тодорхой хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах, хэвлэл, мэдээллийн үйлажиллагаатай холбоотой зарим хуулийг шинэчлэх талаар зөвлөмж гаргаж бодлого боловсруулагчид, мэргэжлийн эвлэл холбоод болон олон нийтэд танилцуулав.

Тэрчлэн 2008 оны УИХ-ын сонгуулиар хамгийн их будлиан дагуулсан сонгуулийн санал тоолох үйл явцад иргэний нийгмийн зүгээс анх удаа нэгдсэн зохион байгуулалттай ажиглалт хийх санаачилгыг ННФ гарган, Сүлжээний гишүүн байгууллагууд, оюутнууд, сайн дурынхны оролцоотойгоор амжилттай хэрэгжүүлж гүйцэтгэлээ. Ажиглалтын зорилго нь сонгуулийн зөрчил будлианаас сэргийлэхэд нам, нэр дэвшигчдийн томилсон ажиглагчдаас гадна иргэний нийгмийн хөндлөнгийн хяналт чухал болохыголон нийт болоод бусад оролцогч талд таниулах, санал тоолох явц зохих журмын дагуу ил тод, маргаангүй явагдахад нөлөө үзүүлэхэд оршиж байв. Уг төслийг Сүлжээний гишүүн Сонгогчдын Боловсрол Төв (СБТ) удирдан хэрэгжүүлсэн бөгөөд ажиглалтын аргачлалыг 2004, 2008 онд УИХ-ын сонгуульд хийсэн мониторингийн туршлага болон Чөлөөт Шударга Сонгуулийн Азиийн Сүлжээний 2007 онд Тайландын сонгуульд хийсэн ажиглалтын аргачлалд үндэслэн боловсруулав. Ажиглалтад нийслэлийн найман дүүргийн 38 хэсгийн хороо (нийслэлд ажилласан нийт хэсгийн хороодын 23 хувь нь) хамрагдсан бөгөөд СБТ-өөс зохион байгуулсан сургалтад хамрагдаж бэлтгэгдсэн 48 ажиглагч дээрх хэсгийн хороодод санал тоолох ажиллагааг хянасан юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН 2009 ОНЫ СОНГУУЛИЙН САНАЛ ТООЛОХ АЖИЛЛАГААНЫ АЖИГЛАЛТ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн санал тоолох ажиллагааны ажиглалт нь санал хураах өдөр 22:00 цагаас хойш зөвхөн санал тоолох явц болон санал хураалтын эцсийн дүнг хэсгийн хороод хуралдан батлах үеийг хамарсан. Төрлийн хувьд суурин ажиглалт бөгөөд сонгуулийн баримт бичгийг тээвэрлэн дээд шатны сонгуулийн хороонд хүргэх ажлыг ажиглаагүй болно. Сонгогчдын төлөөлөгчид нь төслийн багаас урьдчилан боловсруулсан санал тоолох ажиллагааг шалгах хуудас, санал тоолох ажиллагааны үнэлгээний хуудас, санал тоолох үед гарсан өргөдөл, гомдол, хүсэлтийг бүртгэх хүснэгтийг зааврын дагуу бөглөж, цугласан мэдээллээ фото зураг авах, видео бичлэг хийх, баримт бичгийг хуулбарлан авах, урьдчилан бэлтгэсэн ажиглалтын болон үнэлгээний маягт бөглөх аргаар баримтжуулсан байна.

Сонгуулийн хэсгийн хороод нь үйл ажиллагаагаа хаалттай явуулахыг илүүд үзэх хандлагатай байсан агаад санал тоолоход сонгогчдын төлөөллийг байлцуулахаас татгалзах, чирэгдэл учруулах явдал олонтаа гарч байв. Сургалтад хамрагдаж бэлтгэгдсэн 60 ажиглагч харьяа хэсгийн хорооддоо сонгогчдын төлөөлөгчөөр бүртгүүлэх хүсэлт гаргасан боловч 48 нь бүртгүүлж, гурав нь хувийн шалтгаанаар, ес нь хэсгийн хороо бүртгэж авах боломжгүй гэсний улмаас сонгуулийн санал тоолох үйл ажиллагааг ажиглаж чадсангүй.

Нийслэлийн сонгуулийн хэсгийн хороодын 23 хувийг хамруулсан ажиглалтын ерөнхий дүнг танилцуулбал:

- Санал тоолох ажиллагаа хууль тогтоомжийн хүрээнд зөрчил будлиангүй, шударга болж өнгөрсөн. Үүнд иргэний нийгмийн хөндлөнгийн хяналт зохих хэмжээнд нөлөөлсөн гэж үзэж байна.
- Ажиглалт хийсэн зарим хэсэгт зохион байгуулалтын болон тохиолдлын чанартай жижиг зөрчлүүд гарсан ч санал тооллогын дунд сөрөг нөлөө үзүүлээгүй.

Түүнчлэн сонгуулийн хэсгийн хорооны гишүүд, улс төрийн намын ажиглагчдаас авсан санал асуулгаар хорооны гишүүдийн 94.8 хувь, улс төрийн намын ажиглагчдын 87.8 хувь нь санал тоолох үйл ажиллагаа хуулийн дагуу явагдсан гэж хариулжээ. Мөн сонгогчдын төлөөлөгчдийн 97.3 хувь, улс төрийн намын ажиглагчдын 98.9 хувь нь санал тоолох үйл ажиллагааны үед ямар нэг сэжигтэй зүйл ажиглагдаагүй гэсэн бол хэсгийн хорооны гишүүдийн 96.4 хувь, улс төрийн намын ажиглагчдын 98 хувь нь санал тооллогын болон санал хураалтын эцсийн дүн эргэлзээгүй бөгөөд хүлээн зөвшөөрнө гэсэн байна.

Сонгуулийг сонгогчдын болон улс төрийн намуудынитгэлийг бүрэнхүлээсэнхөндлөнгийн, бие даасан байгууллагын өргөн хяналт дор ил тод зохион байгуулах нь сонгуулийн үр дүнд эргэлзсэн аливаа маргаан гарах, сонгуулийн дараа хүчирхийлэл, эмх замбараагүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх сайн нөлөөтэй байдаг. Азийн орнуудын туршлагыг аваад үзэхэд 1980-аад оноос эхлэн Филиппин зэрэг улсад ийм хяналт нь сонгуулийн үйл явцын салшгүй чухал бүрэлдэхүүн хэсэг болжээ. Манай сонгуулийн хууль тогтоомжид сонгууль ил тод байх зарчмыг тунхаглан заасан ч түүнийг хэрэгжүүлэх гол арга зам болох иргэний нийгмийн зүгээс санал тоолох болон

сонгуулийн бусад үйл явцад хяналт тавих боломжийг тодорхой тусгалгүй орхигдуулжээ. Энэ нь иргэний нийгмийн зүгээс санал санаачилга гарган идэвхтэй ажиллахад тодорхой саад учруулсаар байгаа юм.

ННФ цаашид сонгуулийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох үүднээс бүх шатны сонгуульд иргэний нийгмийн зүгээс өргөн хүрээнд хяналт тавих боломжийг бий болгох, тэдний чадавхийг бэхжүүлэхэд бүсийн болон олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэх, өөрийн орны туршлагыг бусад орны сонгуулийн ажиглагчидтай хуваалцан баяжуулахад анхааран ажиллах болно.



ЭДИЙН ЗАСГИЙН ХӨТӨЛБӨР

Дэлхийн санхүү, эдийн засгийн хямрал Монголд үргэлжлэн давалгаалж, 2009 онд нэлээд хүндхэн туссаныг эдийн засгийн аль ч салбарын үзүүлэлтүүдээс харж болно. Нэн ялангуяа барилга, дэд бүтцийн салбаруудад үнийн хоосон хөөрөгдөл, зохиомол эрэлт, эрсдэлд өртөн дампуурсан хөрөнгө оруулалт маш элбэг байна. “Их бүтээн байгуулалт” нэрийн дор их хэмжээний мөнгөн хөрөнгийг, бэлэн мөнгөний нийт урсгалын 30 гаруй хувьтай тэнцэхүйц мөнгийг зогсонги, үр бүтээлгүй зарцуулж дуусаагүй барилга, “элс, хайрга, цемент” болгосон Засгийн газрын алдаатай бодлого нь энэ сүйрэлд голлох нөлөөтэй байсныг эдийн засагчид тэмдэглэж байна.

Манай улсын төсөв, сангийн бодлогод тогтолцооны шинжтэй томоохон султал байгааг энэ удаагийн хямрал тод томруунаар харуулав. Тухайлбал, төсөв, сангийн бодлогыг эдийн засгийн мөчлөг сөрсөн бодлого болгохоос нааш эдийн засгийн хямралтай тэмцэх орон зай Засгийн газарт үүсэхгүй гэдгийг хямрал илтгэлээ.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2009 онд өмнөх оноос 3.3 хувиар буурсан ба ийнхүү буурахад боловсруулах аж үйлдвэрийн салбар 14.2 хувь, металлын худэр олборлолтын дэд салбар 6.2 хувиар унасан нь сөргөөр нөлөөлжээ.

Банкууд дахь хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлийн үлдэгдэл огцом

өсч 583 тэрбум төгрөг буюу нийт зээлийн багцад 22 хувь эзлэх болсон нь банкны системийн хэвийн үйл ажиллагаа доголдож байгааг илтгэж байна. Түүнчлэн 2009 оны эцэст зээлийн эрсдлийн сан 327 тэрбум төгрөгт хүрсэн нь банкууд ийм хэмжээний алдагдал үндсэндээ үүрээд байгааг илэрхийлж байна.

Монголбанк хараат бус үйл ажиллагаа явуулж чадаж байгаа эсэх нь анхаарал татаж байна. Ялангуяа, томоохон эрдэс баялгийн ордууд ашиглалтад орохоор хүлээгдэж байгаа энэ үед мөнгөний бодлого хараат бус байх нь бүр ч чухал. Төв банкны бодлогод тодорхой улс төрийн хүчин, бүлэглэл нөлөөлөх нь өрсөлдөөнийг боомилох, улс төрийн ашиг сонирхол дагасан бүлэглэлүүд хүчирхэгжих, рент хайх үйл ажиллагаа газар авах, шинэ үйлдвэрлэл, үйлчилгээг нухчин дарах сөрөг үр дагавартай юм.

Дэлхийн эрчимтэй хөгжих бүй зах зээлүүдэд шаардлагатай ашигт малтмалын хэрэгцээнд дулдуйдан хоцрогдол, ядуурал, ажилгүйдлээс ангижрах боломж монголчуудад байсаар ирсэн юм. Энэ 2009 он ч үүнийг тойрсонгүй. Олборлох салбарын хүрээнд үүссэн их бужигнаан үүний тод жишээ юм. Стратегийн ач холбогдолтой ордууд ээлж дараалан ашиглагдахаар бэлтгэгдэж байх зуур түүнийг боомилсон улс төрийн халуурал, бизнесийн улайрал, сонирхлуудын мөргөлдөөн олборлох салбарын

ирээдүйг асар хаалттай улстөржсөн болгох хандлага ажиглагдаж байна. Хөрш төдийгүй их гүрнүүдийн стратегийн ач холбогдолд өртсөн Монголын уул уурхайг зөв зүйтэй хөтөн авч явахад иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо улам чухал болж байна.

Байгаль цаг агаарын удаан үргэлжилсэн хүнд сорилтууд уламжлалт мал аж ахуйг эмзээг, өртөмтгий болсныг, ерөөсөө ийм байсныг илтгэн харуулав. Гэхдээ энэ нь уламжлалт мал аж ахуйгаа халж солих, “сууринжуулах” тухай асуудалтай огт хамааралгүй, хамаагүй юм. Харин ч Монгол газар нутагт тохирсон бэлчээрийн хийгээд нөөц тэжээлийн баазтай, усжуулах уян хатан сүлжээтэй, холбоо харилцаа сайтай, нүүж нутаг сэлгэхэд авсаархан болох тухай яриа болохыг сургамж өгүүлж байна. Иймд нүүдлийн мал аж ахуйн баялаг уламжлалыг өөртөө агуулсан технологи, менежментийн эргэлтийн шинжтэй олон талт өөрчлөлтийг хэтийн бодлого, чиглэлтэйгээр авч хэрэгжүүлэх нь 2009 оны зудын гол сургамж болж байна.

Нээлттэй Нийгэм Форум “Эдийн засгийн хөтөлбөр”-ийн хүрээнд улс орны эдийн засгийн төдийлөн судлагдаагүй асуудлуудад олон нийтийн анхаарлыг хандуулах, ахиц дэвшил гаргахад тус нэмэр оруулах үүднээс дараах чиглэлийн төсөл, үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГА

Монгол Улсын 2006 онд нэгдэн орсон Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОҮИТБС)-ыг амжилттай хэрэгжүүлэх нь Нээлттэй Нийгэм Форумын бас нэгэн зорилт юм. 2009 он ОҮИТБС-ыг хэрэгжүүлэхэд тодорхой дэвшил гарсан жил болсон ба үүнд ННФ тодорхой хувь нэмрээ оруулсныг дурдах нь зүйтэй бизээ. Тухайлбал, ОҮИТБС-ын 2007 оны санхүүгийн жилийг хамарсан тайлан 2009 оны гуравдугаар улиралд гарсан нь Монгол Улсын хувьд хоёрдахь удаагийн албан ёсны тайлан юм. Монгол Улс 2010 оны гуравдугаар сарын 9-ний дотор олон улсын баталгаажуулалтын үйл явцад хамрагдаж, баталгаажуулалтын тайланг Олон улсын зөвлөлд хүргэх үүрэг хүлээсэн ба 2009 оны эцсээр баталгаажуулалтын үндсэн ажил хийгдэхэд ННФ-ын зүгээс тал бүрийн дэмжлэг үзүүллээ. Түүнчлэн уг санаачилгыг дотоодод болон олон улсын түвшинд сурталчлах, шийдвэр гаргахад шууд оролцож, цар хүрээг нь тэлэх чиглэлээр тодорхой үйл ажиллагаа явуулсан төдийгүй “Төлсөн Авснаа Нийтэл” (ТАН) иргэний нийгмийн эсвлийн гишүүдийн чадавхийг дээшлүүлэхэд онцгойлон анхаарч ирлээ.

Баталгаажуулалтыг олон улсын бие даасан байгууллага Засгийн газрын санхүүжилтээр явуулах дүрэмтэй тул баталгаажуулагчийг сонгох, санхүүжилтийг нь шийдвэрлэх, ажлын удирдамжийг нь эцслэн боловсруулах зэрэг бэлтгэл ажилд ННФ идэвхтэй оролцлоо. Түүнчлэн баталгаажуулагч ирж судалгаагаа

хийх боломжийг бүрдүүлэх, холбогдох талуудтай уулзарт зохион байгуулахад дэмжлэг үзүүлэв. ТАН эсвлийн гишүүдтэй хамтран баталгаажуулалтын талаар иргэний нийгмийн урьдчилсан үнэлгээг гүйцэтгэж, анхаарах асуудлыг ОҮИТБС-ын Ажлын алба, Ажлын хэсэгт танилцууллаа.

Баталгаажуулалтын урьдчилсан тайланг иргэний нийгмийн байгууллагуудад танилцуулах уулзалтыг баталгаажуулагчийн хүсэлтээр зохион байгуулав. Мөн баталгаажуулагчийн эцсийн тайлантай холбоотойгоор Монгол Улсын тэнцээгүй гэсэн таван үзүүлэлтээр ТАН эсвлийн нэрийн өмнөөс нэмэлт тайлбар гаргаж, Олон улсын зөвлөлийн Баталгаажуулалтын хороонд хүргүүлсэн болно.

2009 онд ОҮИТБС-ын Монгол Улсын хоёрдахь удаагийн нэгтгэл тайланг бэлтгэн гаргасан болно. Энэ тайланд нийт 38 компанийн төлсөн татвар, төлбөрийн нэгтгэлийг Малайз, Монголын хамтарсан “Эрнст энд Янг” аудитын компани гүйцэтгэсэн ба компани, Засгийн газар хоёрын гаргасан тайлангуудын нийт зөрүү нь 775 сая орчим төгрөг болсон байна. Энэ тайлантай холбогдуулан ТАН эсвэлтэй хамтран мэдээ гаргаж, вэб хуудас, өдөртутмын сониноор дамжуулан олон нийтэд хүргэлээ. Түүнчлэн ОҮИТБС-ын бусад оролцогчтой хамтранхэвлэлийн багахуралхийж, тайлангийн дунд олон нийтийн анхаарлыг хандуулахыг зорьж ажиллалаа. Цаашид тайлангийн хугацаа,

чанарыг сайжруулах талаар Ажлын хэсэг болон Үндэсний зөвлөлийн хуралд удаа дараа шаардлага тавьж, оролцогч талуудад уриалав.

ННФ нь Монгол Улсын ОҮИТБС-ын шийдвэр гаргах шатанд иргэний нийгмийн байр суурийг ТАН эвслийн бусад гишүүдтэй хамтран илэрхийлж оролцлоо. Түүнчлэн ажлын хэсгээс зохион байгуулсан дараахь хороод, дэд хэсэгт ТАН эвслийг төлөөлж идэвхтэй оролцлоо. Тухайлбал:

- Баталгаажуулагчийг шалгаруулах үнэлгээний хороо
- 2007 оны Аудиторыг шалгаруулах үнэлгээний хороо
- 2008 оны Аудиторыг шалгаруулах үнэлгээний хороо
- Тайлангийн маягтуудыг шинэчлэх ажлын дэд хэсэг

ОҮИТБС-ыг орон нутагт сурталчлах, тус санаачилгын орон нутгийн салбар зөвлөлүүдийг идэвхжүүлэх талаар анхаарч ажиллалаа. Тухайлбал, Улаанбаатар, Дундговь, Хөвсгөл, Сэлэнгэймийн салбар зөвлөлийн удирдлагатай уулзаж, зарим салбар зөвлөлийн хуралдаанд оролцлоо. Улаанбаатар хотын салбар зөвлөлийг Засаг даргын орлогч ахлан байгуулсан ба нийслэлийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын мэдээллийг олон нийтэд ил болгох вэб хуудас ажиллуулах шийдвэр гаргасан нь үр дүнтэй алхам байв. ТАН эвслийн хамт Дундговь, Дорнод, Хэнтий, Хөвсгөл зэрэг аймагт орон нутгийн удирдлага, уул уурхайн компаниуд, ард олон нийтийн оролцоотой “ОҮИТБС орон нутгаас эхэлнэ” сэдэвт цуврал уулзалт зохион байгуулж, уул уурхайн холбогдолтой орон нутагт тулгамдаад байгаа асуудлаар санал солилцлоо.

Түүнчлэн олон улсын түвшинд ОҮИТБС-ыг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг нь эрчимжүүлэхэд идэвхтэй оролцож ирлээ. ОҮИТБС-ын удирдах дээд байгууллага болох бүх гишүүдийн олон улсын бага хуралд оролцлоо. Түүнчлэн ТАН эвслийн гишүүдийн хамт олон улсын “Төлснөө Нийтэл” сүлжээний, мөн Кавказ, Төв Азийн адил төстэй эвслүүдийн уулзалт арга хэмжээнд оролцож, харилцан туршлага солилцов. Тухайлбал, 2009 оны дөрөвдүгээр сард Казахстаны Алматы хотод болсон “Хөрөнгө оруулалтын гэрээний хариуцлага, ил тод байдлыг дээшлүүлэх нь” сэдэвт сургалт семинаарт Монгол Улс дахь гэрээний ил тод байдлын талаар илтгэл тавьсны зэрэгцээ суралцсан туршлагаас хуваалцах семинарыг Монголын иргэний нийгмийн байгууллагуудын дундзохион байгуулав. Гэрээний ил тод байдлыг дэмжих үйл ажиллагааны хүрээнд ННФ-ын төлөөлөгч Дэлхийн Банк, Олон Улсын Валотын Сангийн захирлуудын зөвлөлийн хамтарсан хуралд оролцож илтгэл тавьсан болно. Жил бүр зохиогддог Кавказ, Төв Азийн бүсийн уулзалтад 2009 оны 10 дугаар сард ТАН эвслийг төлөөлөн оролцож, цаашдын хамтын ажиллагааны чиглэлийг тохирсон билээ. Түүнчлэн “Төлснөө Нийтэл” олон улсын сүлжээний хоёр жилд нэг удаа зохиогддог олон улсын уулзалт Канадын Монреал хотноо болсонд ТАН эвслийн гишүүдийн хамт оролцлоо. Орлогын Ажиглагч Хүрээлэнгийн шугмаар Зүүн өмнөд Азийн бүс нутагт олборлох салбарын ил тод байдлыг дэмжигч шинэ сүлжээ байгуулах зорилго бүхий сургалт, семинаарт /Индонезийн Богор хот/ оролцож, бүс нутгийн ижил төстэй төрийн бус байгууллагатай хамтран ажиллах эхлэлийг тавьсан болно.



ОЛБОРЛОХ САЛБАРЫН БОДЛОГЫН АСУУДЛУУД

Уул уурхайн салбарын тулгамдсан асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлэх, иргэнийн нийгмийн байгууллагуудын чадавхийг үргэлжлүүлэн бэхжүүлэх үүднээст төрөл бүрийн мэдээлэл олон нийтэд хүргэх, сургалт семинар, уулзалтуудад оролцуулах талаар ННФ анхаарч ажиллалаа. Тухайлбал, төсвийн хариуцлага, тогтвортжилтын сан, уул уурхайн хөрөнгө оруулалтын гэрээ, төсвийн ил тод байдал, хөрөнгө оруулалтын гэрээний хэрэгжилт ба хяналт, компанийн нийгмийн хариуцлага, цаг уурын өөрчлөлт, уурхайг хаах асуудлаар ННФ болон хамтрагч бусад байгууллагаас санаачилсан олон арга хэмжээг зохион байгууллаа.

Улс орны хөгжилд онцгой ач холбогдолтой Оюутолгойн ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээг 2009 онд Засгийн газар байгуулсан билээ. ННФ гэрээний төсөлтэй холбоотой хэд хэдэн санал, шүүмжийг боловсруулан олон нийтэд танилцууллаа. Тухайлбал, татварын орчныг боловсронгуй болгох, гэрээ байгуулснаар Монголын талын хүртэх хувь хэмжээ, үүрэх эрсдлийн талаар тодорхой саналуудыг Орлогын ажиглагч хүрээлэнгийн зөвлөхүүдийн хамт бэлтгэн, УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо, Засгийн газрын ажлын хэсэгт танилцуулж, тодорхой хувилбаруудыг санал болголоо.

Гэрээг олон нийтэд ил болгох, ОҮИТБС-ыг заавал хэрэгжүүлэх тухай заалтуудыг ННФ-ын санаачилснаар гэрээний эцсийн хувилбарт оруулсан нь ил тод байдлыг хангах үр нөлөөтэй ажил болсон байна. Гэрээний төслийн талаар иргэний нийгмийн байгууллагуудад мэдээлэх, санал солилцох уулзалтыг зохион байгуулж, үр дүнг нь олон нийт, бодлого боловсруулагчдад хүргэлээ.

Уул уурхайн орлого, гэрээ хэлэлцээрийн ил тод байдлаас гадна лиценз олголтын ил тод байдлыг хангах үүднээс "Лиценз Ажиглагч" лавлагааг 2009 онд үргэлжлүүлэн гаргаж, иргэний нийгэм, олон нийтэд уул уурхайн хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн өөрчлөлт, хөдөлгөөн, онцгойлон анхаарах лицензийн талаар мэдээлэл бэлтгэж сар тутам олон нийтэд хүргэж байна.

ТӨСВИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ИРГЭДИЙН ОРОЛЦОО

Засгийн газрын төсвийн бүрдүүлэлт болон зарцуулалтад байнгын идэвхтэй ажиглалт хийдэг иргэний нийгмийн байгууллагуудын цөмийг бүрдүүлэхэд 2009 онд Нээлттэй Нийгэм Форум анхаарч ажиллалаа. "Иргэд Төсвөө Хянана" сүлжээний гишүүн байгууллагуудтай хамтран Улаанбаатар хот, түүний дүүргүүдийн төсөв батлах үйл явцад мониторинг хийж иргэдэд мэдээлэв. Түүнчлэн Улаанбаатар хотын Багануур дүүрэгт хийгдсэн "Шилэн Түрийвч" аяны үр дүнгийн талаар иргэний нийгмийн байгууллагууд болон орон нутгийн засаг захиргааны төлөөллийг оролцуулан хэлэлцүүлэг хийж, цаашид төсвийн ил тод байдлыг хангах асуудлаар талуудын гүйцэтгэж болох үүргийн талаар ярилцлаа. "Төсвийн мэдээллийг олж авах, ил тод болгох арга замууд" сэдэвт нээлттэй хэлэлцүүлгийг явуулж, төрийн бус байгууллагуудын дунд туршлага солилцлоо.

2009 оны 12 дугаар сард Улаанбаатар хот, түүний дүүрэг, зарим аймаг сумдын 2010 оны төсвийн үйл явцад мониторинг хийх төлөвлөгөө боловсруулсны дагуу төсвийн

төслийг ИТХ-аар хэлэлцэх үеэр "Иргэд Төсвөө Хянана" сүлжээний гишүүд ажиглалт хийв. Мониторингийн үр дүнг 2010 онд хэлэлцнэ. Түүнчлэн сүлжээнээс гадуур төсвийн мониторингийн чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагуудыг шалгаруулж, санхүүгийн болон арга зүйн дэмжлэг үзүүлсний дунд төсвийн ил тод байдлыг хангах, иргэдийн оролцоог дэмжих, төсвийн зарцуулалтын үр ашгийг үнэлэх чиглэлээр төсөл хэрэгжүүллээ. Тухайлбал, ИРИМ байгууллага "Шилэн түрийвчтэй болох нь" гарын авлага, Инфратест байгууллага Сонгинохайрхан дүүргийн засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтын мониторинг, Эмэгтэй Удирдагч Сан Чингэлтэй дүүргийн тохижилт, гэрэлтүүлэг, ногоон байгууламжид зарсан хөрөнгийн мониторинг, Захиргааны Шинэ Санаачилга ТББ Багануур дүүрэгт иргэдийн төсвийн үйл явцад оролцуулах тухай гаргасан журмын хэрэгжилтийн мониторинг, Нийгмийн Дэвшил-Эмэгтэйчүүд хөдөлгөөн төсвийн байгууллагын өөрийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад мониторинг хийх төслийг хэрэгжүүллээ.

ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

2009 он манай улсын хувьд хүндхэн жил болж өнгөрлөө. Дэлхийн санхүү, эдийн засгийн хямрал 2008 оны сүүлийн хагас жил, 2009 оны эхний хагас жилд огцом гүнзгийрч улмаар Монголын эдийн засагт хүчтэй нөлөө үзүүлэв. Хямралын үзүүлж буй бодит нөлөөг тодорхойлох зорилгоор Нээлттэй Нийгэм Форум энэ онд Монгол Улсын Их Сургуулийн Эдийн засгийн сургуультай хамтран хэд хэдэн судалгааны ажил санаачлан хэрэгжүүлсний нэг нь “Дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын Монголын эдийн засагт үзүүлж буй нөлөө” улирлын тайлан юм. Энэхүү тайлангийн хүрээнд дэлхийн эдийн засгийн хямрал Монголын эдийн засагт хэрхэн нөлөөлж гүнзгийрэх, хүндрэл бэрхшээлүүдийг хэрхэн давж болох талаар ажиглалт, саналаа хуваалцахыг зорьсон болно. Тайланд Монгол Улсын эдийн засгийн дотоодын үйлдвэрлэл, гадаад худалдаа, макро эдийн засгийн бодлогод дүн шинжилгээ хийснээс гадна дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын Монголын эдийн засагт нөлөөлж буй сувгууд гэх мэт тодорхой нэг сэдвийг улирал бүр хөндөж судаллаа.

Түүнчлэн манай орны хөдөлмөрийн зах зээл дээр хямралын улмаас гарсан өөрчлөлтүүд, тухайлбал, албан болон албан бус секторууд дахь ажил эрхлэлт, ажилгүйдлийн түвшин, хөдөлмөрийн эрэлт, нийлүүлэлтэд гарч буй өөрчлөлтийн шалтгаан, ажилгүйдлийг бууруулах тухайд төрөөс хэрэгжүүлж байгаа бодлогын талаар албан ёсны статистик болон бусад тоон мэдээн дээр үндэслэсэн

“Хөдөлмөрийн зах зээл ба нийгмийн эмзэг байдал, ядуурал” судалгааг хагас жил тутамд хийлээ. Өнөөгийн санхүү, эдийн засгийн хямралын үед бодлого боловсруулагчид чухам ямар бодлогын сонголтуудыг хийсэн, эдгээр нь амьдралд хэрхэн хэрэгжив, ирээдүйд болзошгүй хямралыг даван туулахад юуг анхаарах шаардлагатай байгаа талаар дэлгэрэнгүй хэлэлцсэн “Дэлхийн санхүү эдийн засгийн хямралын Монголын эдийн засагт үзүүлж буй нөлөө: Монгол Улсын санхүүгийн зах зээл” сэдэвт судалгааг хоёр удаа хийж гүйцэтгэлээ. Монгол Улсын санхүүгийн зах зээлд дүн шинжилгээ хийхийн зэрэгцээ бодлогын сонголтуудын талаар олон нийтэд таниулахад тайлангийн бас нэг зорилго оршиж байлаа. Эдгээр судалгааны үр дүнг цаг тухайд нь товч хэлбэрээр хэвлэн нийтэлж, веб сайтад байрлуулан олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах зэргээр бодлого боловсруулагчид, судлаачид, олон нийтэд хүргэсэн болно. Энэхүү мэдээллүүдийг олон нийт сураглан ашиглаж, Дэлхийн Банк сар тутмын эдийн засгийн тайландаа хамтран ажиллахыг санал болгосон зэрэг нь ийм мэдээлэл нийгэмд аль хэр үгүйлэгдэж байсныг харууллаа.

ННФ-ын 2009 онд санаачлан хэрэгжүүлсэн шинэ ажлын нэг нь санхүү, эдийн засгийн хямралын үед Монголчууд эдийн засгийн байдлыг хэрхэн үнэлж байгаа болон ойрын ирээдүйд ямар хүлээлттэй байгааг тандсан “Хэрэглэгчийн итгэлийн индекс”-ийн судалгаа юм. Энэ судалгааг зургаан сарын зайдтайгаар

хоёр удаа явуулсан бөгөөд судалгааны үр дүнг хэвлэлийн бага хурал зохион байгуулах замаар олон нийтэд шууд хүргэж байлаа. Судалгаа нь хоёр шатлалт санамсаргүй түүврийн аргаар Улаанбаатар хотын нийт 1000 өрхийг хамарсан ба хэрэглэгчийн итгэлийн индексээс гадна ажилгүйдэл, ядуурлын үзүүлэлтийг нийслэл хотын хувьд тооцож гаргасан болно.

ННФ-ын захиалгаар Монгол Улсын Ерөнхий сайд асан Д. Бямбасүрэн “Монгол Улсын макро-эдийн засгийн богино-дунд хугацааны компьютерийн загвар” боловсруулсан нь нийт 99 хувьсагч, 26 оператор функцтэй томоохон загвар болсон юм. Уг загварыг бид их дээд сургууль болон холбогдох яамдад ашиглуулахаар бэлтгэж байна. Зохиогч

загварын эхэнд Монгол Улсын макро-эдийн засгийн сүүлийн гурван жилийн динамикт анализ хийсэн бөгөөд тэрбээр Монгол Улсад төрийн алдаатай бодлогоос улбаалсан дотоодын хямрал 2007 оны дунд үеэс эхэлсэн гэж үзжээ. Дүн шинжилгээг бодлого боловсруулагчид, судлаачид болон олон нийтэд түгээв.

АНУ-ын ОУХА-ын санхүүжилт бүхий Эдийн Засгийн Бодлогын Шинэчлэл, Өrsөлдөх Чадвар төсөлтэй хамтран эдийн засгийн асуудал, бодлогын талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор богино хэмжээний телевизийн нэвтрүүлэг бэлтгэх, өдөр тутмын сонинд нийтлэл хэвлүүлэх ажлыг 2009 онд мөн гүйцэтгэсэн болно.

БИЗНЕСИЙН ОРЧИН

2009 оноос Монгол Улсын өрсөлдөх чадварыг сайжруулах асуудал бодлого боловсруулагчид, судлаачид төдийгүй олон нийтийн анхаарлын төвд орж чухалчлан авч үзэх хандлага ажиглагдаж эхэллээ. Нээлттэй Нийгэм Форум Дэлхийн Эдийн Засгийн Форум /ДЭЗФ/-тай байгуулсан гэрээний дагуу эдийн засгийн өрсөлдөх чадвар, өсөлтөд нөлөөлөх хүчин зүйлүүдийг улс орнуудын хооронд харьцуулан судалдаг Дэлхий дахини өрсөлдөх чадварын тайланд оруулах Монгол Улсын судалгааг Хүман Фортис Консалтанси компанийтай хамтран гүйцэтгэж байна. Энэ жилийн судалгаанд Монголд үйл ажиллагаагаа явуулж буй том, дунд компаниудыг төлөөлсөн 300-аад компанийг түүвэр болгон авсан бөгөөд үүнээс 80 аж ахуйн нэгж санал асуулгад оролцлоо. Судалгааг ДЭЗФ-аас боловсруулсан

аргачлалын дагуу хийдэг бөгөөд түүврийн хэмжээ, жагсаалтыг улс болгоны хувьд тодорхой тайлбар, тооцооллыг нь үндэслэн баталж өгдөг болно.

Удирдах ажилтны санаа бодлын судалгаа буюу “Бизнесийн салбарынхны дуу хоолой” нь “Дэлхий дахини өрсөлдөх чадвар тайлан”-ийн чухал хэсэг бөгөөд тухайн улс орны эдийн засгийн орчин, түүний тогтвортой өсөлтөд хүрэх чадварыг хэмжихэд гол үүрэг гүйцэтгэдэг. Судалгаагаар олоход хэцүү, ховор байдаг маш олон төрлийн хувьсагч бүхий үнэтэй өгөгдөл, мэдээллийг цуглуулж байна.

Энэ жилийн судалгааны тайланд нийт 134 улсаас Монгол Улс 117 дугаар байрт бичигдсэн нь өмнөхжилийнхтэй харьцуулахад 17 байраар ухарсан үзүүлэлт юм. Манай хөрш хоёр орон

болов Хятад, Орос улс нь Монголоос ихэд дээгүүр буюу 29, 63 дугаар байрыг тус тус эзэлсэн байна. (дэлгэрэнгүй мэдээллийг www.forum.mn болон www.gcr.weforum.org хаягаар орж авна уу). “Дэлхий дахинь өрсөлдөх чадварын тайлан 2009-2010” -ийн улс орон бүрт холбогдох мэдээлэлд танилцуулснаар Монголын тэргүүлэх бизнесийн удирдлагууд “бизнес эрхлэхэд хамгийн бэрхшээлтэй хүчин зүйлсэд” дараах шалтгаануудыг тодорхойлжээ. Үүнд төр засгийн хүнд суртал, санхүүжилт олж авах боломж, авилга, бодлогын тогтвортгүй байдал, инфляци, ажиллах хүчний боловсрол, дэд бутцийн хангалтгүй байдал, үндэсний ажиллах хүчний сүл ёс зүй зэргийг дурдсан байна. Манай улс энэхүү тайлангийн нийт 110 үзүүлэлтийн дийлэнхэд нь 100-аас хойш байрт оржээ. Тухайлбал, макро эдийн засгийн тогтвортой байдлын тулгуур үзүүлэлтийн улсын төсвийн ашиг/алдагдлаар 116 дугаар байр, инфляциар 131 дүгээр байр эзэлсэн нь өнгөрсөн онд төсвийн алдагдал ДНБ-ий 5%, инфляци 26.8% байсантай холбоотой юм.

Хэрэгжиж болохуйц тодорхой санал боловсруулан байнгын хяналт тавьж ажиллах

тал дээр хувийн хэвшил, Засгийн газар хоёр хамтранажиллахныулсорныөрсөлдөхчадварыг дээшлүүлэхэд нэн тустай. Энэхүү түншлэлд гарах ололт амжилтыг үнэлж дүгнэхэд Монгол Улсын өрсөлдөх чадварын индекст эзэлсэн жил бүрийн зэрэглэлийг нэг гол үзүүлэлт болгон ашигладаг. Өөрөөр хэлбэл, энэхүү индекст Монголын цаашид эзлэх байр суурь нь ололт амжилтыг хэмжих гадаад хэмжүүр буюу эдгээр хүчин чармайлтын үр дүнг үнэлэх “онооны талбар” болж өгдөг юм. Энэ жилийн хувьд ННФ Үндэсний Хөгжил Шинэтгэлийн Хороотой хамтран өрсөлдөх чадварын судалгааны үр дүнг Засгийн газар, Улсын Их Хурлын гишүүд болон хувийн секторынханд танилцууллаа. Хувийн хэвшлийн зохион байгуулалттай, үр дүнтэй нөлөөллийн асуудал өнөөдөр манай улсад дөнгөж бүрэлдэн тогтох шатандаа явж байна. Томоохон компаниуд хувийн хэлхээ холбоогоороо дамжуулан төр, засгийн байгууллагуудаар асуудлаа шийдвэрлүүлэх хандлагатай байгаа нь жижиг, дунд хэмжээний аж ахуйн газрын хувьд тэр бүр тохиодоггүй хяслан байсаар байна.

ОРОН НУТГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ

Нээлттэй Нийгэм Форум санхүүгийн төвлөрлийг бууруулах ажлын хүрээнд Бүсийн Хөгжлийн Санаачилга ТББ-тай хамтран “Орон нутгийн төсвийн орлогын хуваарилалт” судалгааны ажлыг 2009 онд хийж дууслаа. Энэ ажлын гол зорилго нь төвлөрлийг сааруулах өнөөгийн бодлогын төлөв, бодит байдлыг задлан шинжилж, үнэлгээ өгөхөд оршиж байсан юм. Үнэлгээнд үндэслэн цаашид орон нутгийн

төсвийн тогтвортой, урьдчилан тодорхойлох боломжтой, өөрөө захиран зарцуулах төсвийн орлогыг бий болгох бодлогын хувилбарууд дэвшүүлж, хэрэгжүүлэх арга замуудыг санал болгосон ба судалгааны тайланг бодлого тодорхойлогчид, эрдэмтэн, судлаачдынхүртээл болголоо. Судалгааны үргэлжлэл болгон “Орон нутгийн төсвийн зарлагын шинжилгээ” сэдэвт судалгааг эхлүүлсэн ба орон нутгийн чиг

Үүрэг, орон нутгийн үйлчилгээний хариуцлагыг шинэчлэх боломжийг үндсэн дөрвөн асуудалд тулгуурлан авч үзэх юм. Үүнд:

1. Орон нутгийн үйлчилгээний чанарыг сайжруулж, тоо хэмжээг өргөтгөх боломж,
2. Үйлчилгээний ижил, тэгш хүртээмжтэй байдлыг тодорхойлох, хот ба хөдөөгийн ялгааг багасгах,
3. Төрийн үйлчилгээний үр ашгийг сайжруулах боломж,
4. Нутгийн иргэдийг шийдвэр гаргахад оролцуулах, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх боломж бий эсэхийг судлахад оршино.

Судалгаа нь одоогийн хуулиар орон нутагт олгогдсон чиг үүрэг, түүний бодит байдал, орон нутгийн зарлагын төлөвлөлтийг тодорхойлдог зарчим, журам, үйлчилгээний зардалд нөлөөлөх хүчин зүйлүүд, санхүүгийн дэмжлэгийг хуваарилахад зарлагын хүчин зүйлийг хэрхэн харгалzan үзэж байгаа зэрэгт төвлөрөх болно. Судалгааны ажил нь гурван аймаг, зургаан сум, Улаанбаатар хот, нэг дүүргийг жишээ болгон авч үзнэ. Судалгааны явцад нутгийн удирдлагын байгууллагын хариуцах чиг үүрэг, үйлчилгээ, орон нутаг дахь төв Засгийн газрын үйлчилгээний урсгал болон хувьсах зардалд дүн шинжилгээ хийж, нутгийн удирдлагын чиг үргийг оновчтой

тодорхойлох, төсвийн зарлагын төлөвлөлтийн механизмыг сайжруулах, орон нутагт олгох санхүүгийн дэмжлэгт стандарт зардлыг тооцох аргачлалыг боловсруулж бодлогын зөвлөмж гаргах юм.

Мөн санхүүгийн төвлөрлийг бууруулах ажлын хүрээнд 2009 оны 12 дугаар сарын 3-5-ны өдрүүдэд “Төсвийн төвлөрлийг сааруулах үр ашигтай стратеги боловсруулж хэрэгжүүлэх” сургалтыг Засгийн газрын болон зарим аймгийн ЗДТГ-ын ажилтнууд болон ИТХ-ын тэргүүлэгчид, судлаачид, багш нар, олон улсын байгууллагын ажилтнуудад зориулан явууллаа. Сургалтыг Дьюк-ийн Их сургуулийн Станфордын Төрийн бодлогын сургуулийн Төрийн бодлогын судлалын профессор бөгөөд Төсвийн төвлөрлийг сааруулах ба Орон нутгийн засаг захиргааны төсвийн удирдлагын хөтөлбөрийн захиral Рой Кэлли удирдан явуулсан юм. Түүнчлэн тэрбээр УИХ-ын гишүүдэд зориулан тусгай илтгэл тавьсан юм.

Энэхүү сэдвийн хүрээнд өмнө нь “Оролцогчдын хамтын ажиллагаанд тулгуурлан орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэх ДЕЛТА” төсөлд оролцсон Архангай аймгийн Их Тамир сум Шинэ Зеландын засгийн газрын санхүүжилт бүхий “Алслагдсан орон нутгийн бүлгийг зохион байгуулах”, “Бүлгийн маркетингийн үйл ажиллагааг дэмжих” хоёр төслийг 2009 оноос хэрэгжүүлж эхлэв



НИЙГМИЙН ХӨТӨЛБӨР

Нийгмийн бодлого нь чанартай сайн боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх замаар хүний капитал бий болгох, мөн нийгмийн хамгаалал, халамжийн бодлогоор дамжуулан нийгмийн бүлгүүдийг эмзэг байдалд орохоос сэргийлэх бодлогын чухал хэрэгсэл болох утгаараа Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг нийгмийн хөгжил болгож хувиргахад багагүй үүрэг гүйцэтгэж чадах юм. Монголын Засгийн газар сүүлийн 20 жилийн турш улс төрийн тогтолцоо болон эдийн засгийн харилцаагаа шинэчлэн байгуулахад гол анхаарлаа төвлөрүүлж, харин нийгмийн бодлогоо урсгалаар явуулж ирсэн талтай. Нийгмийн бодлого нь нийт хүн амд чиглэсэн шинжтэй, тодорхой бүлгүүдийн онцлог хэрэгцээг төдийлөн хангаж чадахгүй байсан тул нийгмийн халамжийн зорилтот хөтөлбөр нэмж боловсруулах шаардлага байсаар байна. Өдгөө нийгмийн үйлчилгээг хүртэж чадахгүй байгаа хүмүүст халамжийн арга хэмжээ хүргэдэг буруу тогтолцоо бүрдээд байгаа юм. Тухайлбал, шилжүүлгийн бичиг баримт дутуу гэсэн шалтгаанаар сургуульд орж чадаагүй хүүхдэд саад болж байгаа захиргааны бэрхшээл, тогторыг нь

арилган ЕБС-д хамруулахын оронд албан бус боловсролын тогтолцоо руу оруулаад орхидог жишиг тогтох вий гэхээс хөдөөнөөс хот руу шилжиж ирсэн эцэг эхчүүд эмээж байна.

Нийгмийн бодлого нь хүмүүсийн ялгаатай хэрэгцээг хангаж чадахгүй байгаа нь Монголд нэгэнтээ бий болоод байгаа нийгмийн тэгш бус байдал, нийгмийн ялгаварлыг улам гүнзгийрүүлэх нөлөө үзүүлж ч мэднэ. Нийгмийн тэгш бус байдал нь юуны өмнө эдийн засгийн болон бусад нөөц боломжоор тааруу нийгмийн бүлгүүдэд хамгийн хүнд тусдаг. Засгийн газраас бүх нийтийн боловсрол, нийгмийн хамгааллын тэгш хамралт, эрүүл мэндийн чанартай үйлчилгээг хүн бүрт хүргэх асуудлыг стратегийн зорилт болгон чухалчилж байгаа нь сайшаалтай ч ННФ-аас хийсэн хэд хэдэн судалгаа, мониторингийн үр дүнгээр хөгжлийн бэрхшээлтэй, шилжин суурьшсан болон ядуу, эмзэг бүлгийн олон хүүхэд нийгмийн үйлчилгээ хүртэж чадахгүй байгаа нь харагдаж байна.

Дэлхийн эдийн засгийн хямрал нь Монголд зөвхөн сайн нийгмийн бодлого боловсруулж хэрэгжүүлээд

зогсохгүй бодлогын тушттай байдлыг хангахад онцгой анхаарах хэрэгцээ шаардлага хурцаар тавигдаж байгааг нээн харууллаа. Гадаад худалдааны нэн таатай нөхцөл бүрдээд байсан 2005-2008 оноос хэрэгжих эхэлсэн нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийн заримыг нь нэн даруй хааж, өмнө нь олонтаа давтагдсан улс төрийн амлалтууд “маргаглаа”. Улмаар урьдчилан таамаглахад бэрх дэлхийн зах зээл дээрх ашигт малтмалын үнийг дагаад олон Монгол өрхийн цалин, тэтгэмж, хангамж нь хэлбэлзэж буй нь амьдралаа төлөвлөхөд хүнд болгож, нийгмийн бухимдалд хүргэж байна.

2009 онд ННФ нь боловсрол, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд энэ үйлчилгээнээс гадуур үлдэх магадлалтай хүүхдүүдийн нөхцөл байдалд анхаарч ажиллалаа. Шилжин суурьшигч өрхүүд, нөхцөл боломж багатай орчин нөхцөлд амьдарч байгаа хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс зэрэг нийгмийн эмзэг бүлгүүд энэ жилийн үйл ажиллагааны гол фокус болж байгаа юм.



ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САНААЧИЛГА

Хүүхэд, залуучуудын хөтөлбөрийг хэрэгжүүлэх гол тулгуур болж байсан ерөнхий боловсролын сургууль 1990-ээд оноос эхлэн төсөв, санхүүгийн хямрал, хүний нөөцийн хомсдол, хот суурин газрын анги танхимиын хэт ачаалал зэргээс шалтгаалан зөвхөн танхимиын сургалтад анхаарлаа хандуулах болжээ. Түүгээр зогсохгүй ардчиллаас өмнөх үеийн соёл, олон түмний ажлын агуулга, хэлбэр нь хүүхэд, залуучуудын чөлөөт цагийг сонирхолтой бөгөөдүрөгөөжтэй зохион байгуулах хэрэгцээ шаардлагыг хангаж чадахгүй болсон юм. Улмаар сургуулийн насын хүүхдүүд өдөртөө 3-5 цагийг л хичээлд сууж, өдрийн ихэнхийг хараа хяналтгүй өнгөрөөх нөхцөл бүрдээд байна.

Улс орны эдийн засаг тогтвортхийн хэрээр хот суурин газарт хүүхдийн авьяас чадварыг хөгжүүлэх олон хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн ч дийлэнх нь төлбөртэй учраас боломж муутай өрхийн хүүхдүүд хамрагдаж чадахгүй байна. Хичээлийн бус цагаар хүүхэд оролцсон гэмт хэргийн тоо эрс нэмэгдснээс гадна эцэг эх, асран хамгаалагчийн хараа хяналтгүй энэ л үеэр өсвөр насын хүүхдүүд архи, тамхи хэрэглэх, бусад буруу зан үйлд татагдан ордог болохыг "Америк орон 15 цагаас хойш" судалгаагаар тогтоожээ. Ялангуяа нөөц боломж хязгаарлагдмал, хөрөнгө мөнгөний гачигдалтай өрхийн хүүхдүүд чөлөөт цагаа үр бүтээлтэй өнгөрөөж чадахгүй байгаа нь

тэдний эмзэг байдлыг улам лавшуулах сөрөг нөлөөтэй юм.

Дээрх үндэслэлээр ННФ 2008 онд хичээлээс гадуур хүүхэд, залуучуудыг хөгжүүлэх хөтөлбөрийн уралдаан зарлаж дөрвөн төсөл шалгаруулсан юм. 2009 онд Баянхонгор болон Орхон аймгийн Төв номын сан, “Сод Номун” болон “Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг” төрийн бус байгууллагын төслүүд хэрэгжсэн бөгөөд ННФ санхүүгийн болоод арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллалаа.

Хүүхэд, залуучуудыг хөгжүүлэх хичээлээс гадуурх хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад ийм үйлажиллагааны хэрэгцээ, шаардлага онцгой их байгаа нь харагдаж байна. Хөтөлбөрийн эхний жилийн үйл ажиллагааг загвар бий болгох, туршлага хуримтлуулахад чиглүүлэх үүднээс орон нутгийн хэрэгцээг тодорхойлох жижиг судалгаанууд хийж, жилийн туршид төслийн үйл ажиллагаанд тогтмол оролцох 20 орчим хүүхдтэй бүлгүүд байгууллаа. Улаанбаатар хотын Улаанхуарангийн алслагдсан хороонд байгуулсан “Гэр номын өргөө”-г түшиглэн 20 хүүхдэд танин мэдэхүй, амьдрах ухааны арга барил олгох хөтөлбөр хэрэгжүүлсэн “Сод Номун” ТББ нь төслийн явцад нэмэгдэж ирсэн сонирхогч хүүхдүүд, тэдний эцэг эхэд зориулж Бямба, Ням гаригт нэмэлт үйл ажиллагааг тогтмол явуулжээ. Орхон аймгийн номын сангийн төслийн баг аймгийн төвийн номын санд түшиглэсэн үйл ажиллагаагаа өргөтгөн алслагдсан Говил болон Баянбулаг баг дээр нэмэлт бүлгүүд байгуулан ажиллажээ.

Төслүүд нь тухайн орон нутгийн онцлог, хүүхдийн насны түвшинг тусгасан өвөрмөц агуулгатай ч ННФ-аас боловсруулсан нийтлэг арга зүйд тулгуурлан хэрэгжсэн юм. Бусад орны туршлага, ялангуяа Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн хүүхэд, залуучуудын

хөтөлбөрийн загварыг судалсны үндсэн дээр ННФ дээрх дөрвөн байгууллагад сургалт явуулж, үйл ажиллагааны загвар боловсруулан сар бүрийн ажлаа төлөвлөхөд туслахын зэрэгцээ орон нутаг дахь сайн дурын ажилтан болон бусад нөөц бололцоог дайчлан ашиглах, цаашдаа тогтвортой ажиллахын тулд хөрөнгө босгох стратеги боловсруулахад нь дэмжлэг үзүүллээ.

Хичээлээс гадуурх хөтөлбөр нь хичээлийн бус цагаар насанд хүрсэн хүний хараа хяналттай, аюулгүй нөхцөлд хүүхэд, өсвөр үеийхний нийгмийн харилцааны ур чадвар болон авьяас сонирхлоо хөгжүүлэх орчин бий болгох эрхэм зорилготой. Энэ зорилгыг хэрэгжүүлэх үүднээс дараах зорилтыг баримтлав. Үүнд:

- Сайн дурын ажилтнууд болон орон нутгийн нөөц, бололцоог дайчлах
 - “Сод Номун” ТББ-ын ажилд эцэг эхчүүд болон тэтгэвэртээ гарсан ахмадууд, их дээд сургуулийн оюутнууд сайн дураар идэвхтэй оролцлоо. Орхон аймагт сэтгүүлчдийн санаачилгаар залуу сэтгүүлчдийн клуб ажиллуулж, радио болон сонины газруудад хүүхдүүдийг дадлага хийлгэн бие дааж сонин гаргахад нь туслах, мэргэжлийн чиг баримжаа олгох ажлыг зохион байгуулжээ. Баянхонгор болон Орхон аймагт төр, захирагааны болон төрийн үйлчилгээний байгууллагын ажилтнууд хүүхдүүдэлекц яриа хийж, эмнэлэг, музейн үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлсэн байна.
- Хараа хяналттай орчинд тогтмол үйл ажиллагаа явуулах газартай байх
 - Баянхонгор болон Орхон аймгуудын сургуулийн анги танхимиын ачаалал их тул төслийн үйл ажиллагааг

номын сан болон соёлын төвд, харин Улаанхуарангийн хувьд сургууль, соёлын төв, төрийн үйлчилгээний барилга байшин байхгүй гэр хороолол учраас төслийн хороо задгайд гэр барьж үйл ажиллагаагаа хэрэгжүүллээ.

- Оролцогчдын сонирхлыг өдөөхийн зэрэгцээ ур чадвар, авьяасыг нь хөгжүүлэх зорилгоор үйл ажиллагааг нэг удаагийн бус тодорхой хугацаанд үргэлжлэх байдлаар төлөвлөн хэрэгжүүлэх
 - Орхон аймгийн төслийн баг “Дэлхий ертөнц” сэдвийн хүрээнд Монгол орны газар зүйн бүсчлэл, ургамал, амьтдын талаар хэлэлцүүлэг өрнүүлэн зохион бичих, дүрслэн зурах даалгаврыг орон нутгийн музей үзэх аялалтай хослуулан нийт 7 долоо хоногийн 18 цагийн хөтөлбөр хэрэгжүүлсэн байна. “Сод Номун” ТББ нь “Байгаль хамгаалал” сэдвийн хүрээнд танин мэдэхүйн болон уран зохиолын ном уншин хэлэлцэхийн зэрэгцээ мэргэжилтний удирдлага дор тасалгааны цэцэг үрслүүлэн суулгах дадлага хийж, эцэг эхийн хамт оид зугаалах, чингэхдээ хатуу болон хүнсний хог хаягдлаа ялгах, унасан мөчир болон ургамлын хогийг цэвэрлэх, аяллын үеэр хүүхдийн аюулгүй байдлыг хангах талаарх яриа хэлэлцүүлэг өрнүүлэх зэргээр нийт 4 долоо хоногийн хөтөлбөр хэрэгжүүлжээ.

Эдгээр туршилтын төсөл нь хүүхдүүдийн мэдлэг, ур чадварыг хөгжүүлээд зогсохгүй өөрт нь хэрэгтэй дадал, зуршил суулгахад түлхүү анхаарч байна. Тухайлбал, нэг удаадаа 2-3 цаг үргэлжлэх хичээлийн явцад хүүхдүүд ганцаараа болон багаар янз бүрийн дасгал гүйцэтгэхээс гадна цагийн хуваарийн дагуу 5-10 минут биений тамирын дасгал хийх, тоглох боломжтой.

Хөтөлбөрийн үйл ажиллагаа 2010 оны гуравдугаар сард дуусах бөгөөд төслийн багуудын тайлан, туршлагад үндэслэсэн “Хүүхэд хөгжүүлэх хичээлээс гадуурх үйл ажиллагааны эх сурвалж” номыг 2010 онд хэвлэн гаргах юм.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН ЭРХИЙН ХАМГААЛАЛ

НҮБ-аас 2006 онд баталсан Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нийгмийн амьдралд тэгш оролцож, нийгмийн нөөц боломжоос бусдын адил хүртэхийн зэрэгцээ улс орныхоо хөгжилд хувь нэмрээ оруулах нөхцөл, бололцоог хангаж өгөхөд чиглэсэн чухал баримт бичиг юм. Монгол Улс энэ конвенцид 2008 оны 12 дугаар сард нэгдэн зүйл, заалтыг нь дагаж мөрдөх үүрэг хүлээлээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх бодлого нь зөвхөн төрөөс хэрэгжүүлэх нийгмийн халамж, хамгааллын арга хэмжээгээр хязгаарлагддаггүй агаад ялгаварлан гадуурхалтгүй хандлага, амьдарч ажиллахад саадгүй орчин, хөгжлийн бэрхшээлийг даван туулахад чиглэсэн тусгай бодлого гэх мэт олон асуудлыг багтаадаг. Сүүлийн жилүүдэд Монголын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн төлөө ажилладаг иргэний нийгмийн байгууллагууд бодлогод нөлөөлөх, хэрэгжилтэд нь хяналт тавих ажилд идэвхтэй оролцдог болж байна.

НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийг хэрэгжүүлэхэд нь дэмжлэг болох үүднээс ННФ "Хүний эрхийн төлөө! Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн

эрхийг хамгаалах үйл ажиллагаа, нөлөөлөл" гарын авлагыг англи хэлнээс орчуулан иргэний нийгмийн байгууллагууд, бодлого боловсруулагчид, хэрэгжүүлэгч төрийн байгууллагуудад түгээлээ. Гарын авлагыг АНУ-ын Миннесота мужийн Их сургуулийн Хүний эрхийн мэдээллийн төвөөс гаргасан бөгөөд хүний эрхийн сургалт, нөлөөллийн ажилд өргөн ашиглагдах чухал хэрэгсэл юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн зүйл, заалтууд, зориулалтыг тодорхой тайлбарлаж, хүний эрхийн бусад хуультай хэрхэн уялдаж байгааг товч, энгийн харуулж, хийж гүйцэтгэх дасгал ажлаар баяжуулсан энэ ном нь сургалтад шууд ашиглаж болох давуу талтай. Номын сүүлийн бүлэгт Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн албан ёсны Монгол орчуулга, мөн албан бус хялбарчилсан болон хураангуй эхийг орууллаа. Гарын авлагыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй ажилладаг Монголын болон олон улсын байгууллага, төрийн болон нийслэлийн холбогдох албаны хүмүүс, хот болон хөдөөгийн тусгай сургуулиудад хүргүүлсэн бөгөөд номын нээлтийн үйл ажиллагаанд оролцсон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудын төлөөлөгчид сайшаан хүлээж авсан болно.

НИЙГМИЙН ЭМЗЭГ БҮЛЭГТ ЗОРИУЛСАН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Хөдөөнөөс хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн эрчимжсэн сүүлийн 20 жилд хотын захын хороонуудын нутаг дэвсгэр тэлж, хүн ам эрс нэмэгдэж байна. Нийгмийн болон төрийн үйлчилгээг хүргэх дэд бүтэц сул, хүний нөөц хязгаарлагдмал хотын захын эдгээр дүүрэгт нийгмийн шинжтэй олон асуудал шийдэгдэхгүй хуримтлагдаж байгаа нь 2009 онд ННФ-аас "Зохистой хөгжлийн Жендер төв" ТТБ-тай хамтран Сонгино Хайрхан дүүргийн хоёр хороонд хийсэн судалгаанаас харагдлаа.

Шилжин суурьшигч болон ажилгүй иргэн олонтой эдгээр хороонд оршин суугч 3000 гаруй хүний 300 гаруй нь шилжүүлгийн болон иргэний бичиг баримтын зөрчилтэй, зөвшөөрөлгүй газар буусан зэрэг шалтгаанаар ямар ч бүртгэлгүй амьдарч байна. Хорооны бүртгэл нь төрийн болон нийгмийн үйлчилгээнд хамрагдах нөхцөл, улс төр, эдийн засгийн үйл ажиллагаанд хамрагдах суурь болдог тул эдгээр хорооны хүн ам боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ авах, сонгуульд оролцох, албан секторт ажил хөдөлмөр эрхлэх эрхээ эдэлж чадахгүй байна.

Судалгаанд хамрагсдын 37.8 хувь нь ямар нэг төрлийн нийгмийн халамж авч буй агаад үүний 90.2 хувь нь хүүхдийн нөхцөлт мөнгөн тэтгэмж, 8.2 хувь нь нийгмийн халамжийн тэтгэвэр байна. Судалгаанд хамрагдсан нийт өрхийн 70 хувь нь ядуу өрх гэсэн хорооны албан статистик байгаа хэрнээ ядуу бөгөөд эмзэг бүлэгт чиглэсэн арга хэмжээ нь нийт нийгмийн халамжийн дөнгөж 1.6 хувийг эзэлж байна.

Зөвхөн боловсролын үйлчилгээг аваад үзэхэд сургуульзавсардалтын талаархэсурвалжуудын статистик мэдээлэл хоорондоо зөрүүтэйн дээр бодит байдлыг зөв тусгаж чадахгүй байна. Судалгаанд хамрагдсан хоёр хэсэгт хорооны бүртгэлээр 7 хүүхэд, сургуулийн нийгмийн ажилтны бүртгэлээр 12 хүүхэд сургууль завсардсан байхад өрхийн судалгаагаар 29 хүүхэд илэрсэн байна. Эдгээрийн дотор сургуульд огт яваагүй хөгжлийн бэрхшээлтэй 6 хүүхдээс гадна шилжүүлэг хийлгээгүй тул сургууль авахаас татгалзсан, сурлага муутай, Монгол хэл сайн мэдэхгүй, хувцас муутай зэргээс болж багш, ангийнхан нь гадуурхсан, сургууль хол учраас хүргэж өгч чаддаггүй, эсвэл ажил хийлгэх, гэртээ хүн асруулахаар эцэг эх нь сургуулиас нь гаргасан тохиолдлууд байна.

Тайланд нийгмийн эмзэг бүлгийн хүүхдийн сургууль завсардсан бодит шалтгааныг илрүүлж арилгахын тулд бүртгэл мэдээллийн тогтолцоог сайжруулах, нийгмийн халамж, хүүхэд хамгааллын бодлогын уялдаа холбоог хангах, албан тушаалтуудын ажил үүргийн хуваарийг оновчтой болгоход чиглэсэн зарим арга хэмжээг санал болголоо.

2010 онд ННФ нийгмийн эмзэг бүлгийхний нөхцөл байдал, тэдэнд хүрч байгаа төрийн болон нийгмийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэхээр төлөвлөж байна.



ННФ-ын үйл ажиллагааг
хэрэгжүүлэх арга хэрэгслүүд

ХӨГЖЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТӨВ

Технологийн эрин дэх хэрэглэгчдийн мэдээллийн хэрэгцээг онлайн үйлчилгээгүйгээр төсөөлөх боломжгүй юм. 2004 оноос үйл ажиллагаагаа эхэлсэн Хөгжлийн Мэдээллийн төв 2009 онд шинэ стратегийн дагуу гол мэдээлүүдээ онлайнаар олон нийтэд түгээхэд түлхүү анхаарч энэхүү үйлчилгээг хүргэх арга хэрэгслээ шинэчлэн, онлайн мэдээллийн сангаа баяжуулав. Судалгааны байгууллага, судлаачдын гаргасан мэдээллийг олон нийтэд нээлттэй болгоход зохиогчийн эрхийн асуудал хөндөгдөг. Энэ чиглэлээр eFL.net байгууллагаас зохион байгуулдаг “Номын сангийн үйлчилгээ ба зохиогчийн эрхийн асуудал” сургалт-семинаарт оролцон олон улсын байгууллага, мэргэжилтнүүдийн дэмжлэг, зөвлөгөөг авсан нь уг ажлыг хэрэгжүүлэхэд тустай болов.

Одоогийн байдлаар www.forum.mn вэб сайт дээр судалгааны үндсэн сан (.pdf хувилбараар), дижитал мэдээлэл (хууль, хурлын материал, ном гарын авлага гэх мэт CD-гээр хэвлэгдсэн мэдээлэл), электрон каталоги, гадаадын онлайн сангүүд руу хандах эрхийг агуулсан онлайн мэдээллийн санг ямар нэгэн бүртгэл, төлбөргүйгүйгээр олон нийт ашиглаж эхэллээ. Түүнчлэн өнгөрсөн жилээс туршсан гишүүнчлэлийн үйлчилгээ бэхжиж нийтдээ 60 орчим хувь хүн, албан байгууллага тогтмол үйлчилүүлж 3000 орчим мэдээллийг ашигласан байна.

2009 онд нийтдээ 4,000 орчим хүн Мэдээллийн төвд ирж үйлчилгээ авсан ба тус Төвийн онлайн каталогос (http://www.soros.org.mn/osf_opac) 20,000 гаруй удаа мэдээллийн хайлт хийгджээ. Эндээс харахад ийм тооны онлайн

үйлчилүүлэгчид ханджээ гэж үзэж болох юм. Төвийн хэвлэмэл мэдээллийн сан 250 орчим гадаад, дотоодын шинэ номоор баяжиж хамгийн их уншилттай эхний 10 ном гэрээр 22-48 удаа ашиглагдсан байна.

Номын сангүүдад ННФ-аас хэвлэн гаргаж байгаа шинэ ном, судалгааг түгээх, тараах үйлчилгээний хүрээнд 20 орчим төрлийн 7000 гаруй номыг шуудангаар хүргэж, Үндэсний Номын Санг 2010-2015 онд хөгжүүлэх Стратеги боловсруулах үе шаттай сургалт, семинар зохион байгууллаа. Түүнчлэн Дэлхийн Банкны хамтын ажиллагааны хүрээнд МУИС, Өмнөговь, Дархан-Уул аймгийн номын сангүүдтай Иргэдийн мэдээллийн төвийн сүлжээний хамтын ажиллагаа бэхжиж, хөдөө орон нутагт мэдээлэл түгээхэд эдгээр төв гол хамтрагч болж байна.

Хөгжлийн мэдээллийн төв нь Азийн орнуудын Иргэдийн мэдээллийн төвийн (телецентр) бүсийн сүлжээний гишүүний хувьд сүлжээний уулзалт, зөвлөгөөнд оролцож Мэдээлэл Шуудан Холбоо Харилцааны Газраас хэрэгжүүлэх гэж байгаа хөдөө орон нутагт Телецентр байгуулах ажиллагаанд хэрэглэгдэх мэдээллээр хангаж байна.

Конгрессын номын сангийн ном солилцооны хөтөлбөр, Дэлхийн Банк болон Азийн Хөгжлийн Банкны хэвлэн нийтлэлийн газруудаас өнгөрсөн онд нийтдээ 60 орчим ном, судалгаа хүлээн авсан байна.

Цаашид Хөгжлийн Мэдээллийн төвийн онлайн үйлчилгээнд түлхүү анхаарч, гишүүнчлэлийн болон чөлөөт сонголтын үйлчилээний чанарыг чухалчилна.

“WWW.FORUM.MN” ПОРТАЛ САЙТ

“Нээлттэй Нийгэм Форум” портал сайт нь Монгол дахь бодлого боловсруулах болон хэрэгжүүлэх үйл явц, бодлогын шийдвэрийн талаарх мэдээллээр олон нийтийг хангах,

бодлогод хяналт тавих, үнэлэх зэрэг чиглэлээр 2009 онд доорх ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Нийтлэл & news headlines

Монголын хөгжлийн асуудлаарх нийтлэл, өгүүллийг олны хүртээл болгодог “Онцлох мэдээ” буланд нийтдээ 500 гаруй мэдээ мэдээлэл, нийтлэл, ярилцлагаагуулагджайна. Зонхилох сэдвүүд нь засаглалын асуудлууд, татвар, уул уурхай, байгаль орчин, хүн амын амьжиргаа, хүнс, хөдөө аж ахуй, гадаад, дотоод

бодлого, даяаршлын тухай бөгөөд эрдэмтэн судлаачид, багш нар, сэтгүүлч, төрийн албан хаагчид өөрсдийн бичсэн нийтлэл, өгүүллээ нийлүүлсний зэрэгцээ Монголын улс төр, эдийн засгийн онцлох үйл явдлын талаарх тойм мэдээллийг тогтмол хүргэж байна.

Тогтмол явуулдаг ажиглалтууд:

Сонгуулийн ажиглалт

Энэ ажиглалт нь улс төрийн намуудын сонгуулийн мөрийн хөтөлбөрийн талаарх шүүмж анализ, сонгуулийн үйл явцын мониторинг зэрэг өргөн хүрээтэй мэдээ материалыг нэг дор байрлуулан, олон нийтэд түргэн шуурхай танилцах боломжийг бүрдүүлж, 2009 онд нийтдээ 90 орчим шинэ мэдээ, мэдээллийг багцаар нь хүргэжээ.

Үул уурхай – Хөгжил

2009 онд олны анхаарлын төвд байсан Оюутолгойн гэрээ батлагдаж, Таван толгой, Асгат зэрэг томоохон ордуудын хөрөнгө оруулалтын гэрээ зогсонги байдалд орсон хэвээр байна. Энэ бүх үйл явдлын талаарх цогц мэдээллийг манай портал хүргэсээр ирсэн агаад Стратегийн орд газруудын тухай мэдээллийг агуулсан тусгай хуудас эхлүүлж тэдгээрт холбоотой мэдээллийг цуглуулж байна.

"Төсвийн үйл явц"

Тус портал нь 2004 оноос эхлэн жил бүрийн улсын төсвийг УИХ-аар хэлэлцэн батлах үйл явц, төсвийн хүрээний тодотголтой холбоотой багц мэдээллүүдийг тогтмол толилуулдаг болсон. Тайлангийн хугацаанд 2009 оны төсвийн тодотгол, тухайлбал, төсөв ерөнхийлөн захирагчдын зарлага, орлого, улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламж, гадаад зээлийн ашиглалт, төлбөр зэрэгт холбогдох мэдээ, мэдээллийг түгээлээ. Тухайн жилийн улсын төсвийн дэлгэрэнгүй төслийг бүрэн эхээр нь вэб сайтад байрлуулж, олон нийтийн санал бодлыг нь хүлээн авч хэвшлээ.

Бодлогын асуудал

"Бодлогын асуудал" буланд хууль тогтоох үйл явц дахь иргэдийн оролцоог боловсронгуй болгоход чиглэсэн холбогдох хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, Мэдээлэл авах эрх, эрх чөлөөний тухай хуулийн төсөл, Сонгуулийн үйл явцын эрх зүйн зохицуулалт, 2008 оны УИХ-ын сонгуульд өрсөлдсөн гол намуудын амлалт болох "Эх орны хишиг буюу Эрдэнийн хувь" зэрэг асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлэх зорилгоор тэдгээртэй холбоотой баримт бичиг, судалгаа, санал зөвлөмжийг багцлан толилуулж олон нийтийн санал бодлыг хүлээн авч байна.

Эх сурвалж

Тайлангийн хугацаанд Монголын нийгэм, эдийн засгийн хөгжлийн сэдвээр донор байгууллагууд болон бусад судалгааны төвийн хийсэн 50 орчим шинэ судалгааг бүрэн эхээр нь pdf форматаар байрлуулав. Мөн бодлогын асуудлаар хэвлэгдэж буй ном товхимол, гарын авлагуудыг танилцуулжээ.

2009 онд порталд программ хангамж болон технологийн өөрчлөлт хийгдэж олон нийтэд шинэ өнгө төрхтэйгээр хүрч эхэллээ.

БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР

ННФ бодлого боловсруулах үйл явцад иргэд, иргэний нийгмийн идэвхтэй оролцоог дэмжих, Монголд бодлогын судалгаа, дүншинжилгээний чадавхийг бий болгох зорилготой Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөрийг 2004 оноос хойш хэрэгжүүлж ирлээ. Энэ хугацаанд 60 гаруй судлаач бодлогын холбогдолтой судалгаа, дүн шинжилгээ хийх арга зүйд суралцаж, бодлогын хувилбарт шийдлийг дэвшүүлсэн 25 орчим судалгааны тайлан хэвлэгдээд байна.

Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөрийн боломжийг өргөжүүлж үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор 2009 онд зохион байгуулалтын хоёр өөрчлөлт хийлээ. Өмнө нь хөтөлбөрт зөвхөн хувь судлаачдыг хамруулж байсан бол энэ жилээс багаар ажиллан асуудлыг арай өргөн хүрээнд авч үзэх боломжийг олголоо. Түүнчлэн бодлогын дүн шинжилгээний

чадавхи, туршлагатай судлаачид, багуудыг тэтгэлэгт хамруулахын тулд “Ахлах судлаач” хөтөлбөрийг хэрэгжүүлэв. Жилийн үр дүнгээс харахад багаар ажиллахад судлаачид хоорондоо зөвлөлдөн дэм болж буй нь ажлын явц, чанарт эерэг нөлөө үзүүлдэг ч багийн доторх ажил үүрэг, хариуцлагыг эн тэнцүү хуваарилах, харилцан хяналттай ажиллахад нэлээд цаг, хүч зарцуулдаг нь ажиглагдлаа.

2009 оны Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөрт шалгарч, тэтгэлэг авсан судлаачдын нэр, судалгааны сэдвийг дор харууллаа. Энэ онд хөтөлбөрт хамрагдсан гурван баг судалгаагаа дуусгаж тайлан нь хэвлэгдэж байна. Гурван судалгааны ажил тодорхой шалтгаанаар удааширсан тул 2010 онд дуусах болж, нэг судлаач гадаадад сурах болсноор судалгаагаа үргэлжлүүлэх боломжгүй болжээ.

| Судлаачийн нэр | Үндсэн байгууллага | Судалгааны ажлын сэдэв |
|--|---|--|
| Б. Агни | НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн “Мэргэжлийн хяналтын тогтолцооны хариуцлагыг бэхжүүлэх” төслийн Үндэсний зохицуулагч | Эмнэлгээр үйлчлүүлэгчийн эрхийг хангах нь |
| Б.Булганчимэг | Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага-Дэлхийн Хөдөлмөрийн Байгууллага- GTZ-ийн консорциумын Эрүүл мэндийн даатгалын зөвлөх | Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгох нь |
| С.Дорждагва Н.Түвшинтөгс | УИХ-ын Тамгын Газрын Судалгаа, шинжилгээ, олон нийттэй харилцах төв | Монгол Улсын эрчим хүчний хангамж, зохистой хэрэглээг дэмжсэн эдийн засгийн хөшүүргүүд |
| Д.Бадамдаш Ж.Төртогтох | МУИС-ийн Улстөр судлалын тэнхмийн баг | Улс төрийн намын санхүүжилт |
| С.Цэдэндорж Ж.Бямба-Юу М.Дагва | ШУТИС-ийн Уул уурхайн инженерийн сургуулийн баг | Уурхайг хаах эрх зүйн зохицуулалт |
| Н.Лүндэндорж М.Батсуурь Ч.Өнөрбаяр | МУИС-ийн Хууль Зүйн Сургуулийн баг | Шүүх эрх мэдлийн бие даасан хараат бус байдал |
| Ц.Батсүх Д.Ганбат А.Батпүрэв | Санхүү, Эдийн Засгийн Сургууль ба “Инфорум” ТББ-ын хамтарсан баг | Уул уурхайн орлогыг захиран зарцуулах макро-эдийн засгийн бодлого |

Судлаачдад судалгаа, нөлөөллийн туршлага олгодог энхүү хөтөлбөр нь бодлогын үйл явцыг нээлттэй, сонирхогч талуудын оролцоотой болгох нэг арга хэрэгсэл болж байна. Уралдаант шалгаруулалтаар сонгосон судлаачдад 6-9 сарын хугацаанд арга зүйн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэхдээ бид Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн “Орон нутгийн

засаглалыг бэхжүүлэх санаачилга” хөтөлбөр болон Канадын Карлтоны Их сургуулийн Төрийн захиргааны сургуулийн сургагч, судлаач багш нараас туслалцаа авч хамтран ажилладаг. 2009 онд ННФ анх удаа өөрийн хүчээр бодлогын тайлан бичих гарын авлагыг боловсруулан сургалт явууллаа.

ЭРДМИЙН ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР

Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн Дээд боловсролыг дэмжих хөтөлбөрөөс Зүүн болон Төв Европ, Кавказ, Төв Азийн бус нутаг болон Монголд зориулж Эрдмийн тэтгэлэгт хөтөлбөрийг 2003 оноос хэрэгжүүлж байгаа билээ. Энэ хөтөлбөр нь дэлхийн шилдэг сургуулиас нийгмийн ухааны магистр болон түүнээс дээш зэрэг авсан, төрийн мэдлийн их, дээд сургуулийн нийгмийн ухааны тэнхимд багшилдаг багш нар эрдэм, мэдлэгээ оюутнуудад хүргэхийн зэрэгцээ тэнхмийнхээ сургалтын хөтөлбөрийг шинэчлэхэд оролцоход нь зориулж сарын болон нөхцөлт тэтгэлэг, төсөл хэрэгжүүлэх болон эрдмийн ажил хийх боломж олгож буй юм.

ННФ уг хөтөлбөрийн Монголыг хариуцсан зохицуулагчаар гуравдахь жилдээ ажиллаж байна. 2009-2010 оны хичээлийн жилд Эрдмийн тэтгэлэлт хөтөлбөрт МУИС-ийн Нийгмийн Ухааны Сургуулийн Нийгэм, Соёлын антропологийн тэнхим, МУБИС-ийн Боловсролын Сургуулийн Нийгмийн ажлын тэнхим, мөн ЭМШУИС-ийн Нийгмийн Эрүүл Мэндийн Сургуулийн 20 гаруй багш хамрагдаж байна.

МУИС-ийн Нийгэм-Соёлын антропологийн тэнхим нь 2003 оноос хөтөлбөрт хамрагдаж байгаа ууган түншүүдийн нэг бөгөөд энэ хугацаанд багшах болон эрдэм шинжилгээний чадавхи бүрдүүлэх, сургалтын хөтөлбөр шинэчлэх чиглэлээр олсон амжилтаараа олон орны их, дээд сургуулийг манлайлж байна. Их Британийн Кембридж, Оксфордын Их Сургууль, Франц, Тайванийн Соёл, Урлагийн

сургуулиас магистр, докторын зэрэг авсан эрдэмтэн багш нараар хүчээ сэлбэсэн энэ тэнхмийн зөвлөх багшаар Кембриджийн Их Сургуулийн Нийгмийн антропологийн тэнхмийн эрхлэгч, монголч эрдэмтэн Д.Снийт ажиллаж байна.

МУБИС-ийн Боловсролын Сургуулийн Нийгмийн ажлын тэнхим нь Эрдмийн тэтгэлэгт хөтөлбөртэй дөрвөн жил хамтран ажиллах хугацаанд бакалаврын сургалтын хөтөлбөрөө шинэчлэн боловсруулж дууслаа. АНУ-ын Колумбын Их Сургуулийн Нийгмийн ажлын сургуулийн магистрын сургалтыг дүүргэсэн эрдэмтэн багш нарын хүчээр энэхүү шинэчлэлийг амжилттай хэрэгжүүлж байгаа агаад 2009-2010 онд Колумбын Их Сургуулийн Нийгмийн ажлын сургуулийн багш Д.Бюрнеттэй хамтран ажиллаж байна.

ЭМШУИС-ийн Нийгмийн Эрүүл Мэндийн Сургууль нь Эрдмийн тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдаж байгаа сургуулиудаас хамгийн залуу нь юм. Уг сургууль нийгмийн эрүүл мэндийн бакалавр, магистрын түвшний сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулахаар АНУ-ын Олбани хот дахь Нью Йорк мужийн Их Сургуулийн Нийгмийн Эрүүл Мэндийн Сургуулийн эрдэмтэн багш Л.Макнат, Д.Карпентер нартай хамтран ажиллаж байна.

2010-2011 оны хичээлийн жилд Эрдмийн тэтгэлэгт хөтөлбөртэй түншлэн ажиллах тэнхим, багш нарын өргөдлийг 2010 оны дөрөвдүгээр сард хүлээн авч долдугаар сард сонгон шалгаруулна .

ХЭВЛЭН НИЙТЛЭЛ

Бодлого боловсруулах, хэрэгжүүлэх ажиллагаанд иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо жилээс жилд идэвхжиж оролцооны аль ч хэлбэрт бодит баримт, анализ судалгаан дээр тулгуурласан мэдлэг мэдээлэл олж авах хэрэгцээ шаардлага ёсч байна. Нөгөө талаас төрийн бодлого боловсруулахад найдвартай эх сурвалжаас гаргасан судалгааны дүн, бодлогын альтернатив хувилбаруудыг харьцуулан судалж ашиглаж эхэлж байна. Энэхүү ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор Нээлттэй Нийгэм Форум 2009 онд эдийн засаг, улс төр, ардчилал, иргэний нийгмийн хөгжлийн сэдвээр 20 гаруй судалгааны тайлан, иргэдийн гарын авлага, ном зүйн цуврал, орчуулгын бүтээл гаргалаа. Эдгээрээс иргэдэд зориулсан “Нээлттэй сонсгол”-ын гарын авлагыг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэргэдэх Иргэний танхимиын нээлтийг тохиолдуулан гаргасан нь иргэд сонирхсон хуулийн төсөлд саналаа нэмэрлэх аргазүй, хэлэлцүүлэгт оролцох дүрэм журамтай танилцахад нэлээд тустай бүтээгдэхүүн болов. Түүнчлэн “Монгол Улсын шүүхийн шинэтгэлийн өнөөгийн байдал” сэдэвт судалгаа нь шүүхийн байгууллагын талаар олон нийт шүүмжлэлтэй ханддаг асуудлуудыг олон улсын аргачлалд тулгуурлан авч үзснээрээ мэргэжлийн байгууллагын ажилтнуудын анхаарвал зохих мэдээлэл болов.

Дэлхийн эдийн засгийн хямрал Монгол Улсад хэрхэн нөлөөлж байгаа талаар улирал тутам судалсан дүнг электрон ба цаасан хэлбэрээр

хэвлэн бодлого боловсруулагчид болон олны хүртээл болголоо. Түүнчлэн хямралын үед Хэрэглэгчийн итгэлийн индекс, Хөдөлмөрийн зах зээл, эмзэг бүлгийн байдал, Санхүүгийн зах зээлийн талаар хагас жил тутам судлан шинжилсэн нь цаг үеэ олсон ажил байлаа.

Форумаас 2010 онд хэвлэсэн зарим номын нэрийг дурдвал:

- Уул уурхайн салбарын бодлогын зарим асуудал /судалгааны тайлан/
- Хариуцлагатай төр: Санхүүгийн төвлөрөл, нутгийн өөрөө удирдах ёс /хурлын илтгэлийн эмхэтгэл/
- Дэлхийн санхүү, эдийн засгийн хямрал Монголын эдийн засагт нөлөөлөх нь /улирал тутмын тайлан/
- Төрийн худалдан авах ажиллагаа ба авилга /судалгааны тайлан/
- Монгол Улсын шүүхийн шинэтгэлийн өнөөгийн байдал /судалгааны тайлан: Англи, Монгол хэлээр/
- Орон нутгийн төсвийн орлогын хуваарилалтыг зохицой хангах нь /Судалгааны тайлан: Англи, Монгол хэлээр/
- Нээлттэй сонсгол: Бодлого боловсруулах үйл явцад оролцох нь /иргэдийн гарын авлага/
- ТББ-аас Төрийн үйлчилгээнд хийсэн мониторинг III

- Монголын эрчим хүчний асуудалд холбогдох ном зүй /Англи, Монгол хэлээр/
- Хүний эрхийн төлөө/Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан гарын авлага/
- Монгол Улсын санхүүгийн зах зээл /2009 оны эхний ба сүүлийн хагас жилийн судалгааны дүн/
- Хэрэглэгчийн итгэлийн индекс /2009 оны эхний ба сүүлийн хагас жилийн судалгааны дүн/
- Монгол Улсын макро эдийн засгийн анализ /судалгааны тайлан/.

Нээлттэй Нийгэм Форумын 2003 оноос эхэлсэн хэвлэн нийтлэлийн хүрээнд эдүгээ 120 гаруй ном, гарын авлага хэвлэгдснээс ТББ-уудаас “Төрийн үйлчилгээнд хийсэн мониторингийн тайлан”, жил бүрийн “Эдийн засгийн эрх чөлөөний тойм”, бодлогын судалгааны тайлангууд, тодорхой сэдвээр иргэдэд зориулан бэлтгэсэн гарын авлага зэрэг нь олны танил бүтээгдэхүүн болоод байна. Эдгээрийг хот, хөдөө орон нутаг дахь нийтийн болон их дээд сургуулиудын нийт 350 номын сангаар дамжуулан олны хүртээл болгодгоос гадна УИХ-ын гишүүд, төрийн бус байгууллагууд, ННФ-ын уулзалт хэлэлцүүлэгт оролцогчдод байнга түгээж байна.

ОРЧУУЛГЫН ТӨСӨЛ

Өнөөгийн нийгэмд өрнөж буй хөгжлийн чухал асуудлуудыг таньж мэдэх, өөр өнцгөөс харах, тэдгээрийн онолын үндэслэл, бусад орны туулж өнгөрүүлсэн туршлага сэлттэй танилцаад дэлхийд нэрд гарсан эдийн засагч, судлаач, зохиогчдын бүтээлийг эх хэлнээ орчуулан олны хүртээл болгох нь маш чухал ач холбогдолтой билээ. Нээлттэй Нийгэм Форум 2004 оноос МонСудар Хэвлэлийн Газартай хамтран эхлүүлсэн орчуулгын төслийн хүрээнд нийтдээ 10 ном хэвлэсэн ба сүүлийн хоёр жилд ННФ бие даан нийт таван ном орчуулан хэвлэснээс “Эдийн засаг энгийнээр” ном хоёрдахь удаагаа хэвлэгдээд байна.

2009 онд уг төслийн хүрээнд “Адагт үлдсэн тэрбум: Хамгийн ядуу буурай орнууд хэрхэн

сүйрэн унаж байгаа болон энэ талаар юу хийж болох тухай өгүүлэх нь” номыг орчуулан олны хүртээл болгов. Орчуулгын номууд нь иргэдийн иргэний боловсролд тус нэмэр болох төдийгүй төрийн бодлого боловсруулахад анхаарч үзэх нэмэлт мэдээллийн хэмжээнд ашиглагдаж буй юм. 2008 онд ННФ-ын эрхлэн гаргасан “Сүйрэл” ном БСШУЯ-наас зарласан “Шилдэг ном” уралдаанд шалгарч нийтийн номын сангудад хүргэгдлээ.

2009 онд ННФ-ын орчуулгын төслийн хүрээнд хэвлэгдсэн номууд олон түмэнд илүү танигдаж, тодорхой хэмжээгээр борлуулагдан дараа дараагийн ном орчуулж хэвлэх санд зохих хувь нэмрээ оруулж эхэллээ.

БУСАД

“ДОРНО ДОРНО - ХИЛ ХЯЗГААРГҮЙ ТҮНШЛЭЛ” БУСИЙН ХӨТӨЛБӨР

Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн Дорно Дорно: Хил хязгааргүй түншлэл хөтөлбөр нь үзэл бодол, мэдээлэл болон туршлага солилцох зорилгоор иргэний нийгмийн төлөөлөгчид, төрийн бус байгуулагуудыг хил хязгааргүйгээр бусийн хэмжээнд хамтран ажиллаж, хамтын хүчээр хүмүүнлэг ардчилсан нийгмийг байгуулах үйл ажиллагааг дэмжих зорилготой. 2009 оны долдугаар сард Лондон дахь Дорно Дорно хөтөлбөрийн захирал Мэри Франсис Линдстром Монгол Улсад хүрэлцэн ирж төрийн бус байгууллагуудын төлөөлөгчидтэй уулзлаа. Тэрбээр хөтөлбөрийн Монгол дахь үйл ажиллагааг хариуцдаг Нээлттэй Нийгэм Форумын үйл ажиллагаатай танилцаж цаашид ардчилсан нийгмийг бэхжүүлэхэд чиглэсэн бүх төрлийн төслийг санхүүжүүлж дэмжлэг үзүүлэх боломж нээлттэй байгааг тэмдэглэн хэлсэн юм.

Жил бүр Монголын нийгмийн салбарын экспертууд, идэвхтнүүд Дорно Дорно хөтөлбөрийн хүрээнд олон улсын хэмжээний хурал, семинар, сургалтуудад оролцож байна. 2009 оны хувьд Дорно Дорно хөтөлбөрөөс дэмжлэг авсан нэг чухал төсөл бол Польш улсын Меркури сантай хамтран Ардчиллын Боловсрол Төвийн хэрэгжүүлсэн “Хүчирхийллийн тойргийг таслах нь” төсөл байлаа. 2008 оноос эхэлсэн уг төслийн үр дүнд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 16 үндэсний зөвлөгч бэлтгэн “Хувь

хүн, хүмүүс хоорондын харилцааны чадварыг дээшлүүлэх нь”, “Хүчирхийллийн тойргийг зогсох нь” сэдэвт сургалтуудад хамруулж, Польш улсад туршлага судлах боломж олгосон. Түүнчлэн гэр бүлийн хүчирхийллийн сэдвээр сургалт явуулах сургагч багш нар, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллаж буй төрийн болон төрийн бус байгууллагын ажилтнууд, эмнэлгийн ажилтнууд, сэтгэл зүйч, сургууль, хүүхэд, залуучууд гэр бүлтэй ажилладаг нийгмийн ажилтнуудад болон гэр бүлийн хүчирхийллэд өртөгсдөд зориулсан гарын авлагууд гаргаж нийтийн хүртээл болгоод байна. Эдгээр гарын авлагад гэр бүлийн хүчирхийллийн талаар суурь мэдээлэл, энэ чиглэлээр ажилладаг дотоодын мэргэжлийн байгууллагуудын лавлах зэргийг багтаажээ.



2009 онд Дорно-Дорно: Хил хязгааргүй түншлэл хөтөлбөрийн тэтгэлэгт хамрагдагсад

| № | Оролцогчдын нэрс | Байрлал | Хурал, семинарын агуулга | Огноо |
|----|------------------|------------------------------|---|----------------------------|
| 1. | Б. Мөнхсоёл | Румын улсын Тимесора хот | Хөтөлбөр зохицуулагчдын бүсийн уулзалт | 2009 оны 6 сарын 22-28 |
| 2. | Д. Сэнгэлмаа | Азербайжан улсын Баку хот | Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг сайжруулж өргөжүүлэх нь | 2009 оны 10 сарын 11-12 |
| 3 | Н. Баярсайхан | Азербайжан улсын Баку хот | Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг сайжруулж өргөжүүлэх нь | 2009 оны 10 сарын 11-12 |

2008 онд Дорно-Дорно хөтөлбөрийн хүрээнд хэрэгжсэн төслүүд

| № | Төслийн нэр | Оролцогч байгууллага | Байрлал | Огноо |
|----|-------------------------------------|----------------------------|------------------------------------|---------------------------|
| 1. | Хүчирхийллийн тойргийг таслах нь | Ардчиллын боловсрол төв | Польш улсын Скларска Пореба хот | 2009 оны 5 сарын 10-16 |

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нээлттэй Нийгэм Форум 2009 онд нийт 1,471,000 ам.долларын төсөвтэй ажилласан ба үүнээс \$ 1,006,000 Нээлттэй Нийгэм Хүрээлэн, \$ 224,000 Соросын сангийн сүлжээний хөтөлбөрүүд, \$ 97,500 АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг, \$25,000 - Олон Улсын Төсвийн Төсөл, \$ 38,500 Дэлхийн Банк, \$ 30,000 Орлогын Ажиглагч Хүрээлэн, \$ 50,000 Шинэ Зеландын Элчин Сайдын Яам болон бусад донор байгууллагаас санхүүжигдсэн болно. Төсвийн зарцуулалтыг дор хүснэгтээр харуулав.

Нийт зарцуулалт

\$ доллар

| Хөтөлбөр | Тэтгэлгийн зардал | Үйл ажиллагааны зардал | Нийт зардал |
|---|-------------------|------------------------|------------------|
| ЗАСАГЛАЛЫН ХӨТӨЛБӨР | | | |
| Хүний эрх | 35,701 | 38,427 | 74,128 |
| Шүүхийн хараат бус байдал | 12,033 | 8,833 | 20,866 |
| Төрийн ил тод хариуцлагатай байдал, Иргэний нийгмийн оролцоо | 85,459 | 62,198 | 147,657 |
| Чөлөөт, шударга сонгууль | 25,835 | 8,467 | 34,302 |
| Хэвлэл мэдээллийн эрх чөлөө | - | 1,089 | 1,089 |
| ЭДИЙН ЗАСГИЙН ХӨТӨЛБӨР | | | |
| Олборлох үйлдвэрийн ил тод байдлын санаачилга | 7,216 | 56,229 | 63,445 |
| Олборлох салбарын бодлогын асуудлууд | | 21,131 | 21,131 |
| Төсвийн ил тод байдал ба иргэдийн оролцоо | 83,652 | 2,920 | 86,572 |
| Эдийн засгийн хөгжлийн дүн шинжилгээ | 5,000 | 221,429 | 226,429 |
| Бизнесийн орчин | | 9,269 | 9,269 |
| Орон нутгийн эдийн засгийн хөгжил | 15,922 | 80,653 | 96,575 |
| НИЙГМИЙН ХӨТӨЛБӨР | | | |
| Хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих санаачлага | 5,248 | 2,652 | 7,900 |
| Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хамгаалал | | 3,875 | 3,875 |
| Нийгмийн эмзэг бүлэгт зориулсан төрийн үйлчилгээ | 10,449 | 7,968 | 18,417 |
| ФОРУМЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭРЭГСЭЛ | | | |
| Хөгжлийн мэдээллийн төв | - | 37,409 | 37,409 |
| Портал сайт | - | 35,085 | 35,085 |
| Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөр | 71,826 | 14,148 | 85,974 |
| Эрдмийн тэтгэлэгт хөтөлбөр | | 14,337 | 14,337 |
| Орчуулгын төсөл | | 5,823 | 5,823 |
| Дорно Дорно хөтөлбөр | 20,819 | 3,225 | 24,044 |
| ЗАХИРГАА | | | |
| НИЙТ ДҮН | 379,160 | 960,570 | 1,339,730 |

Нийт олгосон тэтгэлгийн тоо

| Хөтөлбөр | Байгуулагад олгосон | Хувь хүнд олгосон | Нийт олгосон тэтгэлгийн тоо |
|--|------------------------|----------------------|--------------------------------|
| ЗАСАГЛАЛЫН ХӨТӨЛБӨР | | | |
| Хүний эрх | 4 | 8 | 12 |
| Шүүхийн хараат бус байдал | 2 | | 2 |
| Төрийн ил тод хариуцлагатай байдал, Иргэний нийгмийн оролцоо | 16 | | 16 |
| Чөлөөт, шударга сонгууль | 3 | | 3 |
| Хэвлэл, мэдээллийн эрх чөлөө | | | - |
| ЭДИЙН ЗАСГИЙН ХӨТӨЛБӨР | | | |
| Олборлох үйлдвэрийн ил тод байдлын санаачилга | | 5 | 5 |
| Олборлох салбарын бодлогын асуудлууд | | | - |
| Төсвийн ил тод байдал ба иргэдийн оролцоо | 17 | | 17 |
| Эдийн засгийн хөгжлийн дүн шинжилгээ | | 1 | 1 |
| Бизнесийн орчин | | | - |
| Орон нутгийн эдийн засгийн хөгжил | 2 | 2 | 4 |
| НИЙГМИЙН ХӨТӨЛБӨР | | | |
| Хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих санаачлага | 1 | | 1 |
| Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хамгаалал | | | - |
| Нийгмийн эмзэг бүлэгт зориулсан төрийн үйлчилгээ | 3 | | 3 |
| ФОРУМЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭРЭГСЭЛ | | | |
| Хөгжлийн мэдээллийн төв | | | - |
| Портал сайт | | | - |
| Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөр | | | - |
| Эрдмийн тэтгэлэгт хөтөлбөр | | 16 | 16 |
| Орчуулгын төсөл | | | - |
| Дорно Дорно хөтөлбөр | 1 | | 1 |
| ЗАХИРГАА | | | |
| НИЙТ ДҮН | 49 | 32 | 81 |

Нийт зарцуулалт

\$ доллар

| Хөтөлбөр | Байгуулагад олгосон | Хувь хүнд олгосон | Нийт олгосон тэтгэлгийн тоо |
|--|---------------------|-------------------|-----------------------------|
| ЗАСАГЛАЛЫН ХӨТӨЛБӨР | | | |
| Хүний эрх | 15,521 | 20,180 | 35,701 |
| Шүүхийн хараат бус байдал | 12,033 | | 12,033 |
| Төрийн ил тод хариуцлагатай байдал, Иргэний нийгмийн оролцоо | 85,459 | | 85,459 |
| Чөлөөт, шударга сонгууль | 25,835 | | 25,835 |
| Хэвлэл, мэдээллийн эрх чөлөө | | | - |
| ЭДИЙН ЗАСГИЙН ХӨТӨЛБӨР | | | |
| Олборлох үйлдвэрийн ил тод байдлын санаачилга | | 7216 | 7,216 |
| Олборлох салбарын бодлогын асуудлууд | | | |
| Төсвийн ил тод байдал ба иргэдийн оролцоо | 83,652 | | 83,652 |
| Эдийн засгийн хөгжлийн дүн шинжилгээ | | 5,000 | 5,000 |
| Бизнесийн орчин | | | |
| Орон нутгийн эдийн засгийн хөгжил | 12326 | 3,596 | 15,922 |
| НИЙГМИЙН ХӨТӨЛБӨР | | | |
| Хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих санаачлага | 5,248 | | 5,248 |
| Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хамгаалал | | | |
| Нийгмийн эмзэг бүлэгт зориулсан төрийн үйлчилгээ | 10,449 | | 10,449 |
| ФОРУМЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭРЭГСЭЛ | | | |
| Хөгжлийн мэдээллийн төв | | | - |
| Портал сайт | | | - |
| Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөр | | 71,826 | 71,826 |
| Эрдмийн тэтгэлэгт хөтөлбөр | | | |
| Орчуулгын төсөл | | | |
| Дорно Дорно хөтөлбөр | 20,819 | | 20,819 |
| ЗАХИРГАА | | | |
| НИЙТ ДҮН | 271,342 | 107,818 | 379,160 |

2009 онд олгосон нийт тэтгэлгийн жагсаалт

\$ доллар

| № | Байршил | Тэтгэлэг хүртэгчийн нэрс | Төрөл | Тэтгэлгийн дүн |
|----|------------------|---|-------|----------------|
| 1 | Говь-Алтай аймаг | Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүд Хөдөлгөөн Говь-Алтай аймгийн салбар | ТББ | 3,408 |
| 2 | Говь-Алтай аймаг | Хэрэглэгчийн Эрх Ашгийг Хамгаалах Нийгэмлэг Говь-Алтай аймгийн салбар | ТББ | 3,237 |
| 3 | Говьсүмбэр аймаг | Хэрэглэгчийн Эрх Ашгийг Хамгаалах Нийгэмлэг Говьсүмбэр аймгийн салбар | ТББ | 2,362 |
| 4 | Дархан-Уул аймаг | Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв Дархан-Уул аймгийн салбар | ТББ | 3,583 |
| 5 | Дархан-Уул аймаг | Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүд Хөдөлгөөн Дархан Уул аймгийн салбар | ТББ | 3,243 |
| 6 | Дорнод аймаг | Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүд Хөдөлгөөн Дорнод аймгийн салбар | ТББ | 3,066 |
| 7 | Дорнод аймаг | Буйр нуур, Халх гол, Нөмрөгийн сав газрыг хамгаалах Хөдөлгөөн | ТББ | 3,457 |
| 8 | Дундговь аймаг | Хөдөөгийн Эмэгтэйчүүдийг Дэмжих Сан Дундговь аймгийн салбар | ТББ | 1,773 |
| 9 | Завхан аймаг | Ногоон Тэс | ТББ | 3,403 |
| 10 | Өвөрхангай аймаг | Худалдаа аж Үйлдвэрийн Танхим Өвөрхангай аймгийн салбар | ТББ | 3,385 |
| 11 | Өвөрхангай аймаг | ЛЭОС Өвөрхангай аймгийн салбар | ТББ | 2,779 |
| 12 | Өвөрхангай аймаг | Орон Нутгийн Санаачилга Өвөрхангай аймгийн салбар | ТББ | 2,596 |
| 13 | Төв аймаг | Дэлгэр Энх Мөнх | ТББ | 1,984 |
| 14 | Ховд аймаг | Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүд Хөдөлгөөн Ховд аймгийн салбар | ТББ | 3,125 |
| 15 | Хөвсгөл аймаг | Итгэлийн Бяцхан Элч | ТББ | 2,479 |
| 16 | Улаанбаатар хот | Ардчиллын Боловсрол Төв | ТББ | 20,819 |
| 17 | Улаанбаатар хот | Норовбанзад Сан | ТББ | 10,617 |
| 18 | Улаанбаатар хот | Филантропи Хөгжлийн Төв | ТББ | 9,339 |
| 19 | Улаанбаатар хот | Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүд Хөдөлгөөн | ТББ | 8,480 |
| 20 | Улаанбаатар хот | Глоб Интернэшил | ТББ | 8,015 |
| 21 | Улаанбаатар хот | Фортuna Сан | ТББ | 6,126 |

| | | | | |
|----|-----------------|--|--------|--------|
| 22 | Улаанбаатар хот | Захиргааны Шинэ Санаачилга | ТББ | 3,433 |
| 23 | Улаанбаатар хот | Монголын Худалдаа Эд Хэрэглэгчдийн Хоршоолын Төв Холбоо | ТББ | 5,607 |
| 24 | Улаанбаатар хот | Олон Нийтийн Боловсрол Судалгааны төв | ТББ | 4,425 |
| 25 | Улаанбаатар хот | Хөгжлийн Цонх | ТББ | 3,722 |
| 26 | Улаанбаатар хот | Хүний Эрхийн Боловсрол Төв | ТББ | 6,426 |
| 27 | Улаанбаатар хот | Эрчим Хүчний Инженерүүдийн Холбоо | ТББ | 4,744 |
| 28 | Улаанбаатар хот | Гэр булийн Сэтгэцийн Эрүүл Мэндийг Хамгаалах Нийгэмлэг | ТББ | 3,472 |
| 29 | Улаанбаатар хот | Монголын Хөрөнгийн Зах Зээлийн Холбоо | ТББ | 4,566 |
| 30 | Улаанбаатар хот | Хүний Нөөц Нийгмийн Төлөвшил | ТББ | 5,827 |
| 31 | Улаанбаатар хот | Монголын Нягтлан Бодох Бүртгэлийн Хүрээлэн | ТББ | 3,693 |
| 32 | Улаанбаатар хот | Мэдээлэл Шинжилгээ Үнэлгээний Төв | ТББ | 3,284 |
| 33 | Улаанбаатар хот | Тэнгэрийн Таалал Сан | ТББ | 4,762 |
| 34 | Улаанбаатар хот | Соён Тайга Сан | ТББ | 2,688 |
| 35 | Улаанбаатар хот | Алхам Төв | ТББ | 2,724 |
| 36 | Улаанбаатар хот | Хараат Бус Судалгааны Хүрээлэн | ТББ | 3,709 |
| 37 | Улаанбаатар хот | Монголын Тэргэнцэртэй Иргэдийн Холбоо | ТББ | 5,702 |
| 38 | Улаанбаатар хот | Төмөр Сан | ТББ | 3,457 |
| 39 | Улаанбаатар хот | Зориг Сан | ТББ | 4,079 |
| 40 | Улаанбаатар хот | Монголын Байгаль хамгаалах Иргэний Хөдөлгөөнүүдийн Эвсэл | ТББ | 14,553 |
| 41 | Улаанбаатар хот | Монголын Хуульч Эмэгтэйчүүдийн Холбоо | ТББ | 7,057 |
| 42 | Улаанбаатар хот | Монголын Байгальорчны төлөөх Хуульчдын Холбоо | ТББ | 5,339 |
| 43 | Улаанбаатар хот | Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв | ТББ | 10,280 |
| 44 | Багануур дүүрэг | Нүүрэнтэй Илч | ТББ | 3,042 |
| 45 | Налайх дүүрэг | Нийгмийн Тусын Төлөө Сан | ТББ | 3,686 |
| 46 | Улаанбаатар хот | Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз | Төрийн | 5,248 |
| 47 | Улаанбаатар хот | Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгийн Газар | Төрийн | 1,188 |
| 48 | Улаанбаатар хот | Бизнес Талант | ХХК | 6,200 |
| 49 | Улаанбаатар хот | "Иргэд Төсвөө Хянана" Иргэний нийгмийн сүлжээ | Эвсэл | 31,153 |

| Байгууллагуудад олгосон нийт тэтгэлгийн дүн | | | | 271,342 |
|---|-----------------|----------------|-------|---------|
| 1 | Архангай аймаг | Ц.Мөнхбат | иргэн | 1,798 |
| 2 | Хөвсгөл аймаг | Ц.Хөвсгөлдалай | иргэн | 1,798 |
| 12 | Улаанбаатар хот | А.Батпүрэв | иргэн | 1,550 |
| 14 | Улаанбаатар хот | А.Батпүрэв | иргэн | 2,800 |
| 7 | Улаанбаатар хот | А.Дунгармаа | иргэн | 3,542 |
| 18 | Улаанбаатар хот | Б.Агни | иргэн | 3,800 |
| 30 | Улаанбаатар хот | Б.Баярням | иргэн | 1,130 |
| 25 | Улаанбаатар хот | Б.Булганчимэг | иргэн | 2,900 |
| 8 | Улаанбаатар хот | Б.Урна | иргэн | 3,542 |
| 5 | Улаанбаатар хот | Г.Баясгалан | иргэн | 3,542 |
| 20 | Улаанбаатар хот | Д.Бадамдаш | иргэн | 2,800 |
| 15 | Улаанбаатар хот | Д.Ганбат | иргэн | 2,800 |
| 6 | Улаанбаатар хот | Д.Мөнхгэрэл | иргэн | 3,542 |
| 4 | Улаанбаатар хот | Д.Цэрэнжав | иргэн | 846 |
| 11 | Улаанбаатар хот | Д.Цэрэнжав | иргэн | 1,550 |
| 10 | Улаанбаатар хот | Д.Эрдэнэчимэг | иргэн | 1,550 |
| 28 | Улаанбаатар хот | Ж.Амарсанаа | иргэн | 9,976 |
| 26 | Улаанбаатар хот | Ж.Бямба Юу | иргэн | 3,500 |
| 21 | Улаанбаатар хот | Ж.Төртогтох | иргэн | 4,000 |
| 3 | Улаанбаатар хот | Ж.Хунан | иргэн | 210 |
| 31 | Улаанбаатар хот | Л.Мандваа | иргэн | 1,130 |
| 23 | Улаанбаатар хот | М.Батсуурь | иргэн | 3,500 |
| 27 | Улаанбаатар хот | М.Дагва | иргэн | 3,500 |
| 29 | Улаанбаатар хот | Н.Баярсайхан | иргэн | 1,720 |
| 22 | Улаанбаатар хот | Н.Лүндэндорж | иргэн | 7,750 |
| 17 | Улаанбаатар хот | Н.Түвшинтөгс | иргэн | 3,800 |
| 16 | Улаанбаатар хот | С.Дорждагва | иргэн | 2,800 |
| 19 | Улаанбаатар хот | С.Цэрэндорж | иргэн | 8,400 |
| 9 | Улаанбаатар хот | Т.Алтангэрэл | иргэн | 3,542 |

| | | | | |
|---------------------------------------|-----------------|------------|-------|----------------|
| 13 | Улаанбаатар хот | Т.Батсүх | иргэн | 6,000 |
| 24 | Улаанбаатар хот | Ч.Өнөрбаяр | иргэн | 3,500 |
| 32 | Улаанбаатар хот | Р.Катер | иргэн | 5,000 |
| Хувь хүнд олгосон нийт тэтгэлгийн дүн | | | | 107,818 |
| НИЙТ ТЭТГЭЛГИЙН ДҮН | | | | 379,160 |

Нээлттэй Нийгэм Форум

Удирдах зөвлөлийн гишүүд

| | |
|--------------|--|
| Г. Уранцоож | Удирдах зөвлөлийн дарга , Хүний Эрх-Хөгжил төвийн тэргүүн |
| Д. Ганбат | Удирдах зөвлөлийн гишүүн, Улс Төрийн Боловсролын Академийн захирал |
| Ч. Хашчуулун | Удирдах зөвлөлийн гишүүн, Үндэсний Хөгжил -Шинэтгэлийн хорооны дарга |
| С. Цэрэндорж | Удирдах зөвлөлийн гишүүн, Хүний Эрх -Ардчилал судалгааны төвийн тэргүүн |
| Т. Үндарьяа | Удирдах зөвлөлийн гишүүн, MONFEMNET үндэсний сүлжээний зохицуулагч |
| О. Энхтуяа | Удирдах зөвлөлийн гишүүн, Nature Conservancy олон улсын байгууллагын Монгол дахь захирал |
| Г. Эрдэнэбат | Удирдах зөвлөлийн гишүүн, МУИС-ийн Хуулийн Сургуулийн багш, Ерөнхийлөгчийн хуулийн зөвлөхийн шадар туслах |

Гүйцэтгэх захирал

П.Эрдэнэжаргал jargal@forum.mn

Ажилтнууд

| | | |
|-----------------|---|---------------------|
| П.Бадамрагчаа | Засаглалын хөтөлбөр хариуцсан менежер | badmaa@forum.mn |
| Н.Дорждарь | Эдийн засгийн хөтөлбөр хариуцсан менежер | dorjdari@forum.mn |
| Б.Мөнхсоёл | Эдийн засаг, Хэвлэл мэдээллийн хөтөлбөр хариуцсан менежер | soyoloo@forum.mn |
| А.Гэрэлмаа | Нийгэм, Боловсролын хөтөлбөр хариуцсан менежер | gerelmaa@forum.mn |
| Д.Энхцэцэг | Засаглалын хөтөлбөр хариуцсан менежер | enkhee@forum.mn |
| Д.Сэнгэлмаа | Хөтөлбөрийн зохицуулагч | sengelmaa@forum.mn |
| Д.Долгорсүрэн | Хөтөлбөрийн туслах ажилтан | assistant@forum.mn |
| О.Оюунсаруул | Хөтөлбөрийн туслах ажилтан | passistant@forum.mn |
| Д.Балжид | Мэдээллийн төвийн менежер | baljid@forum.mn |
| Д.Баярмаа | Мэдээллийн төвийн туслах ажилтан | dircassist@forum.mn |
| Д.Гантуяа | Порталын ерөнхий редактор | gantuya@forum.mn |
| Д.Жавхлан | Санхүү, захиргааны захирал | javkhlan@forum.mn |
| Д.Аюуш | Нягтлан бодогч, тэтгэлэгийн менежер | ayush@forum.mn |
| Д.Өлзийбадрах | Мэдээлэл сүлжээний зохицуулагч | ulzii@forum.mn |
| Т.Отгонбаяр | Захирлын туслах | otgoo@forum.mn |
| Б.Баатар | Жолооч | baatar@forum.mn |
| Г.Цэдэвхүү | Жолооч | tsedev@forum.mn |
| Ц.Саруул | Жолооч | saruul@forum.mn |
| Ш.Ганчимэг | Захиргааны туслах ажилтан | ganaa@forum.mn |
| Нийтлэг Имэйль: | | osf@forum.mn |